

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 04 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэж, 8 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 13 өргөдөл бичгээр хүлээн авч, 6 өргөдлийг шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 өргөдөл бичгээр хүлээн авснаас 2 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 20 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 19, биечлэн 1 иргэн санал, гомдол ирүүлснээс гомдол 14, санал хүсэлт 4, шүүмжлэл 2 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 19 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэн шийдвэрлэлт 95 хувьтай байна.

Орчны эрүүл ахуйн чиглэлээр 4, хууль эрх зүй 4, эрүүл мэнд 1, боловсрол 1, бусад 10 санал хүсэлт хүлээн авсан байна. Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу энэ сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна. Засгийн газрын 1111 төвөөс 12 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж 9 санал хүсэлтийн хариуг илгээж, 3 санал хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон бусад бодлогын зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, аймаг орон нутгийн өмнө тулгамдаж байгаа асуудлууд, цаг үеийн ажлаар холбогдох байгууллагуудын удирдлагууд болон албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгөх, санал дүгнэлтийг нь сонсох, Засаг даргын Тамгын газрын хэлтэс болон харъяа агентлагууд, аж ахуйн нэгж албан байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, менежментийг сайжруулахад шаардлагатай мэдээллээр хангах, цаашид анхаарах чиглэл, зорилтыг оновчтой төлөвлөн хэрэгжилтийг хангуулахад чиглүүлэн аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөр удирдлагуудад тодорхой үүрэг чиглэлийг өгч, өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг эргэж мэдээлж байх, мэдээллийн агуулга тавигдах шаардлагыг журамлан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 4 дүгээр сард ирсэн санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг санхүүжүүллээ.

Орон нутгийн төсвийн 175 байгууллага, төсөл, сангийн 41, ОНӨААТҮГ-ын 7 нийт 223 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсныг хүлээн авч хянан “Е” цахим тайлангаар нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлээд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн санхүүгийн болон гүйцэтгэлийн тайланг 4 дүгээр сарын 1-20-ны өдрүүдэд аймгийн аудитын газраар хянуулж зөрчилгүй дүгнэлт өгөв. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 9 сумын санхүүгийн алба

болон төсөвт байгууллагууд, аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаатай танилцаж үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байна.

Нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” хөтөлбөрийг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн саналыг тусган аймгийн ИТХ-д хүргүүлэв.

Аймгийн санхүүгийн дотоод аудитын хороо хуралдаж нийгмийн даатгалын, халамжийн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын санхүүгийн үйл ажиллагааг хянаж шалгасан дүнг хэлэлцэн баталж Сангийн яаманд хүргүүлэв. Сангийн яамнаас төсвийн тодотгол хийж, цаашид орон нутгийн 2017 оны тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчим чиглэлийн талаар албан бичиг ирснийг аймгийн ЗДТГ-ын болон холбогдох агентлагын удирдлагуудад хүргүүлж хэрэгжилтэнд анхааран ажиллаж байна. Сангийн яамнаас төсвийн төлөвлөлт, хэрэгжүүлэхтэй холбогдсон 2 төрлийн судалгаатай танилцан судалж саналаа хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн 2016 оны 1 дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж цаашид анхаарах асуудал чиглэлийн танилцуулга бичиж боршурт номоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга, ЗДТГ-ын удирдлагууд, холбогдох салбарын ажилтан албан хаагчдад түгээв. Үүнд:

Орон нутгийн төсвийн суурь орлогод 1751,8 сая төгрөг орж төлөвлөгөө 129,7 сая төгрөгөөр буюу 6,9 хувиар тасарсан байна. Үүнээс татварын орлогоор 1590,2 сая төгрөг орж төлөвлөгөө 82,4 сая төгрөгөөр буюу 4,9 хувиар, хөрөнгийн орлого 99 хувиар, татварын бус орлогоор 161,6 сая төгрөг оруулж төлөвлөгөө 21,0 сая төгрөгөөр буюу 11,5 хувиар тус тус тасарсан байна. Төсвийн орлогын бүрдүүлэлтийг сумдаар авч үзэхэд Дарви, Дуут, Дөргөн, Мянгад сумд 0,2-15,4 сая төгрөгөөр давуулан биелүүлж бусад сумдын төлөвлөгөө тасарсан байна.

Дээд шатны төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 13,2 сая төгрөгөөр дутуу ирсэн.

Энэ улирлын байдлаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 486,2 сая төгрөг оруулахаас 274,3 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 211,9 сая төгрөгөөр дутуу буюу 56,4 хувиар, аймагт төвлөрүүлэх орлогод 1864,6 сая төгрөг оруулахаас 1460,0 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 404,6 сая төгрөгөөр дутуу буюу 78,3 хувиар биелүүлсэн байна.

Иймд орон нутгийн төсвийн орлогын ихэнх нэр төрөл тасарч байгаад холбогдох сум, байгууллагын удирдлагууд анхаарах хэрэгтэй байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 17031,2 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 2992,6 сая төгрөгөөр, үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 4163,8 сая төгрөг хүрч, 181,9 сая төгрөгөөр, орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын зарлага 9971,0 сая төгрөгт хүрч 443,5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зарлага 256,4 төгрөгт хүрч, төсөвлөснөөс 60,8 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй гарсан урьдчилсан дүнтэй байна.

Энэ улиралд төсөв эдийн засгийн ангилалаар болон төсвийн захирагчаар хэтрээгүй байна. Энэ нь төсвийн орлого бүрдүүлэлт хангалтгүй болон аймаг, сумдын төрийн сангаас хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа зэргээс шалтгаалж байна.

Орон нутгийн удирдлагын салбарын төсвийн өр 106,0 сая, авлага 522,7 сая төгрөг болж өр 14,9, авлага 473,1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтэнд аймгаас 313,8 сая төгрөг олгосон нь 3,4 сая төгрөгөөр дутуу байгаа ба сумдад олгосон санхүүжилтийг гүйцэт зарцуулж бүртгэлд тусгахгүй байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 26,7 сая төгрөг орж төлөвлөгөө 57,8 хувийн биелэлттэй байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын төсвийн зарлага 9971,0 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 443,5 сая төгрөгөөр дутуу гарч төсвийн захирагч, эдийн засгийн ангиллаар хэмнэлтэй гарсан байна.

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлага 1061,5 сая төгрөг гарсан нь төлөвлөснөөс 48,2 сая төгрөгөөр дутуу гарч, өр 27,8 сая, авлага 11,8 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 32,9 сая төгрөгөөр буурч, авлага 0,1 сая төгрөгөөр өссөн байна. Өрийг оны эхэнтэй харьцуулахад 16,2 сая төгрөгөөр өссөн байна.

Боловсрол, соёлын салбарын төсвийн зарлага 8752,7 сая төгрөг гарсан нь төлөвлөснөөс 393,9 сая төгрөгөөр дутуу гарч, өр 165,7 сая, авлага 39,8 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 486,0 сая төгрөгөөр, авлага 27,0 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Өрийг оны эхэнтэй харьцуулахад 78,9 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт өрийг эдийн засгийн ангиллаар задлахад ажиллах хүчинтэй холбогдсон зардал 114,7, тогтмол зардал 62,7, эм, хоол 22,1, шатахуун 3,6 томилолт 4,3 бараа үйлчилгээний бусад зардал 29,6 тэтгэмж 6,3 сая төгрөгийн өр ихэнхийг эзэлж байна.

Санхүү, хяналт аудитын албанаас энэ сард аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2015-2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж 13,6 сая төгрөг, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 3,6 сая төгрөг, нийт 17,2 сая төгрөгийн төлбөр илрүүлж орон нутгийн төсвийн орлогод оруулахаар шийдвэрлэлээ.

Статистикийн 4 дүгээр сарын графикт 5 төрлийн мэдээг 245 аж ахуйн нэгжээс, 1 дүгээр улирлын 17 төрлийн мэдээг 328 аж ахуйн нэгжээс батлагдсан маягт аргачлалын дагуу авч программд шивж Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв.

Аймгийн мал аж ахуйн дэлгэрэнгүй танилцуулгыг сүүлийн 3 жилээр хийж Хэлтэс албадын дарга нарт хүргэж ажиллав. Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Хайрхан, Дуут сумын Босго, Мянгад сумын Гахайт багуудад, ажиллах хүчний судалгааг Жаргалант сумын Рашаант, Чандмань сумын Тахилт, Дуут сумын Шивэр багуудад нийт 62 өрхөд хийж судалгааны материалаа хянан шалгаж байна.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Сумдын захирамж, тушаал хянах тухай албан бичиг, хуваарийн дагуу Ховд, Чандмань, Дуут, Мөст сумдын захирамж, тушаалыг хууль тогтоомжийн хэрэглээ, үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр, хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргасан эсэх талаар хянан дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэв.

Хэлтсийн хурлыг 5 удаа хийж, 4 иргэнд хууль зүйн зөвлөгөө өглөө.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, ЗООНОЗ өвчин судлалын төв зэрэг байгууллагууд Захиргааны ерөнхий хуулиар, УЦУОШГ, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал сэдвээр сургалт зохион байгуулав.

“Гэмт хэргийн талаар мэдээлэл худалдан авах”, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих”, “Нийтийн эргүүл

ажиллуулах” зэрэг журмын төсөлд иргэд, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн нөлөөллийн шинжилгээ хийж байна.

“Тайван-Амгалан-Ховдчууд” хөтөлбөрийг батлуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барилаа.

Архивын салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойд баруун 5 аймгийн төрийн архивын удирдлагууд болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын дунд урлаг, спорт, ур чадварын бүсийн наадам 4 сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, бүсийн тэмцээнд 77 хүн оролцлоо. Архивын тасгаас 30 хүнд захирамж, тушаалын лавлагааг олгосон бөгөөд 5 хөмрөгийн 67 хадгаламжийн нэгжийн 3312 хуудас материалыг цахим системд шивж оруулав.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2017 оны 04 дүгээр сарын 24-ний байдлаар 30 гэмт хэрэг бүртгэгдсэн. Гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл, бусдын бие махбодид гэмтэл учруулах 5, хулгайлах 9, үүнээс иргэдийн өмчийн хулгай 4, малын хулгай 5, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 5, бусдын эд хөрөнгө завших 3, бусдын эд хөрөнгө залилан мэхлэх 1, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2, бусад гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдсэн байна.

Цагдаагийн газраас тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 294 гомдол мэдээлэл хүлээн авсаны гэмт хэрэг 74 буюу 25.0 хувийг гэмт хэргийн талаарх, 220 буюу 75.0 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн гомдол мэдээллийг төрлөөр нь ангилан үзвэл, Хулгайлах 32, бусдын бие махбодид гэмтэл учруулах 9, хүний амь нас хохирсон 2, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 15, танхайрсан 2, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 5, согтуу тээврийн хэрэгсэл жолоодсон 64, цахим сайтаар бусдыг гүтгэж, доромжлох 1, булаалт 2, бусад 144, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 8, зам тээврийн осол 5 гомдол мэдээлэл тус тус бүртгэгдсэн байна.

2017 оны 04 дүгээр сарын 24-ний байдлаар зөрчил гаргасан 93 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 27 хүнийг 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлуулж, 40 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 1440 хүнийг 50.510.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн газартай хамтран “Авто замын ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад жолооч, тээвэрчдийн оролцоо” сэдэвт сургалтыг 36 хүнд, аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих” тухай 227 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион явуулж, холбогдох мэдээлэл хийлээ. Жаргалант сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газраас төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулахад оролцож, албанд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, иргэдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх эвхмэл, дэлгэмэл үзүүлэн материал байрлуулан олон нийтэд сурталчилж, санамж, зөвлөмж тараав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх, энгийн харуул манаа, жижүүр, сахиулуудын сонор сэрэмжийг дээшлүүлэх, байгууллага, аж ахуйн нэгжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Харуул хамгаалалтын үндэсний холбоотой хамтран мэргэжлийн үнэмлэх олгох сургалтыг Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн үйлчилгээний ажилчид болон энэ чиглэлээр ажиллах хүсэл

сонирхолтой 35 иргэнийг хамруулсан ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

Тамхины хяналтын тухай хуулийг иргэд олон нийтэд сурталчлах, хуулиар харъяалуулсан үүргийг нь гүйцэтгүүлэх зорилгоор “Тамхины хяналт шалгалт” арга хэмжээг зохион явуулж, Жаргалант сумын 92 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн алба хаагчдад хууль сурталчлах, сургалт яриа таниулгыг хийлээ. Мөн “Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт Ховд аймагт” нэвтрүүлэг бэлтгэн сурталчлав. Өсвөр насны хүүхдүүдийн дунд сургуулийн орчинд бие биенээ дарамтлах, мөнгө нэхэх асуудал гарч байгаатай холбогдуулан “Үе тэнгийнхний дарамт шахалт, аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршиг”-ийн талаар уулзалт ярилцлагыг Жаргалант, Дуут, Дарви, Зэрэг, Манхан, Чандмань сумын сургуулийн 2500 гаруй сурагчдад зохион явуулж, сонирхсон асуултанд хариулт өгч, харилцан ярилцлаа.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны 2016-2017 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу спортын арга хэмжээг Прокурорын газартай хамтран зохион байгуулж албан хаагчдын чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэв.

Шүүхийн шинжилгээний албанд 30 албан бичиг, 54 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 24 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Албаны 1 дүгээр улирлын тайланг хэлэлцэж, тайлангийн хуралд аймгийн прокурорын газрын төлөөллийг оролцуулан цаашид хамтран ажиллахад анхаарах асуудлын талаар санал солилцов.

Алтай, Үенч, Булган, Мөст, Цэцэг сумд, Хөшөөт тосгонд “Нээлттэй хаалганы өдөр” хийж, албаны 2016, 2017 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан хэлэлцэж өөрийн чиг үүрэгт хамааралтай хууль тогтоомжуудаар сургалт зохион байгуулав. Буянт голын сав дагуух газрын хогийг цэвэрлэж аймгийн ногоон хөгжилд хувь нэмрээ орууллаа.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 5 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 53 хүнд, химийн шинжилгээ 11, биологийн шинжилгээ 10, бэлгийн холбогдолтой 1 шинжилгээ, криминалистикийн шинжилгээ 21 тус тус хийж, 101 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд 5 удаа явж үүрэгт ажлаа гүйцэтгэв.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 56 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 28 мөр, гутлын мөр 18, тээврийн хэрэгслийн мөр 16, бусад ул мөр, эд мөрийн баримт 50-ийг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 18, 7 гарын мөр авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийлээ.

Аёааі ààñ ääðäñàí äýì òèèéí çýäýä òí äòì î õ ø èí æèëäýý, áçòòèèí ø èí æèëäýý, химийн шинжилгээ, биологийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүрт нь цахимжуулав.

Албаны үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй. 2017 онд улсын төсвөөс нийт 187,519,000 төгрөгийн төсөв батлагдсанаас 2017 оны эхний 4 сарын байдлаар: Цалин хөлс нэмэгдэл урамшил, Нийгмийн даатгал, ХАОАТ, хангамж бараа материалын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд нийт 55.702.895 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд төлбөрт үйлчилгээний орлогод 1.160.000 төгрөг төвлөрүүлээд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Тус алба нь нийт 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар хүний нөөц сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 1, шийдвэр гүйцэтгэгч 2, хянагч 2, нийт 5 албан хаагч томилогдоогүй 59 алба хаагчтай ажиллаж байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж ажиллаж ирсний зэрэгцээ 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг хичээл сургалт жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна. Аймгийн аварга шалгаруулах 35-аас дээш насны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд тус албаны эрэгтэй баг тамирчид оролцож 1 дүгээр байр эзэлсэн амжилтыг үзүүллээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын иж бүрэн шалгалт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус албаны үйл ажиллагаанд 2017 оны 04 дүгээр сарын 26-29-ны өдрүүдэд иж бүрэн хяналт шалгалт хийж онц сайн үнэлгээтэй дүгнэгдэв.

Тус албаны цагдан хорих байр болон конторын барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 9 ялтныг барилгын туслах ажилтнаар ажиллуулж байна.

Хорих ангийн харуул хамгаалалтыг "Хорих ангийн харуул хамгаалалт болон ялтанд хяналт тавих журам"-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албаны даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна. Ангийн байрлалаас 800 м-т байрлах Малын хэсэгт нэр бүхий 1 хянагчийн хяналтанд нэр бүхий 2 ялтныг ажиллуулж, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу шалган нэмэлт үүрэг даалгавраар ханган тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба - Хорих 457 дугаар ангийн үйл ажиллагаа хууль журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд ялтан, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Улсын бүртгэлийн хэлтэс: Энэ сард нийт 6338 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 5278, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 488 ба шилжин ирсэн иргэд 157, шилжин явсан иргэд 69 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 262, гадаад паспорт олголт болон сунгалт 1583, иргэний үнэмлэх шинээр олгосон 585, сунгалт 580, дахин олгосон 418, иргэний бүртгэлийн лавлагаа 595 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 1029 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 868, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 181 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан. Иргэдээс нийт 11 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 2 өргөдөлийг шийдвэрлэж, 3 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлж, 6 өргөдлийн хугацаа болоогүй байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсрол соёлын чиглэлээр: Монгол улсын засгийн газрын англи хэлний үндэсний хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын соёл мэдээллийн төвд англиар ярих ярианы клуб, олон улсын мэдээний цагийн англи хэлний ярианы хичээл, англиар кино үзэх цаг, англи дууны цагийн хичээлүүдийг ЭТК, СДА хамтарч явууллаа. Тус сургалтанд Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн 12 дугаар ангийн 27 сурагч, 48 багш хамрагдлаа.

2016-2017 оны хичээлийн жилийн мэргэжлийн хичээлийн олимпиадын хоёрын даваа амжилттай зохион байгуулагдаж, ерөнхий боловсролын 24 сургууль, ХоИС-ийн лицей сургуулийн багш, сурагчдын 25 баг оролцлоо. Мэргэжлийн хичээлийн улсын олимпиадын хоёрын даваанд 15 хичээлээр багшийн 16 төрөлд 531 багш, сурагчийн 34 төрөлд 850 сурагч нийт 1380 багш сурагч оюун ухаан, авьяас чадвараа сорин өрсөлдлөө.

Олимпиаданд оролцогсдыг байр эзлүүлэн эхний 3 байр эзэлсэн багш, сурагчдыг боловсролын газрын өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж шагналд 1680,0 мянган төгрөг зарцууллаа. СӨБ, ЕБСургуулийн 2, 3, 4 дэх жилдээ ажиллаж буй багш нарыг чадваржуулах сургалт 4 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд болж нийт 177 багш хамрагдсан. Залуу багш нарын холбооноос зохион байгуулсан “Чадварлаг залуу багш нар”-ын анхдугаар зөвлөгөөн болж зөвлөгөөнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй ЕБС, СӨБ-ын байгууллагын 40 хүртэлх насны нийт 310 багш оролцож, лекц, илтгэл, нэгдсэн хэлэлцүүлэг, бүтээлийн үзэсгэлэн, эцэг эх, сурагчдын уулзалт, спортын тэмцээн зэрэг арга хэмжээнүүд амжилттай зохион байгуулагдлаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллага болон Онцгой байдлын газартай хамтран “Өсвөрийн аврагч” тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд Жаргалант сумын 7 сургууль, Манхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 8 баг 40 хүүхэд оролцож залуу өсвөрийн аврагч клубын үйл ажиллагааг дэмжих хувцас хэрэгслээр хангав.

Булган, Үенч, Алтай, Мөст сумдын соёлын төв, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, хяналт үнэлгээ хийж ажиллаа.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн “Сайн хичээл” сургалт аргагүйн зөвөлгөөн боллоо. Сургууль, багш нарын тэргүүний арга технологийг судлан, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх технологийг улам боловсронгуй болгох, аргагүйг нь дээшлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор “Сайн хичээл сургалт аргагүйн зөвөлгөөн” хийлээ. Нийт 9 судлагдхуун, 6 сургалтыг дэмжих үйл ажиллагаагаар бүсээс шалгарч ирсэн 5 бүлгийн 75 багшийн үйл ажиллагаанд зөвөлгөө өгч, сайн туршлагын сан бүрдүүлээ. Энэ үйл ажиллагаанд 200-аад багш хамрагдлаа.

Жаргалант сумын VI, Прогрес, Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 5, 9, 12 дугаар ангийн сурагчдаас боловсролын чанарын үнэлгээний төвийн шалгалт авав.

Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч болон эцэг эх, цэцэрлэгийн эцэг эхтэй уулзалт хийж санал бодлыг нь сонслоо. Нийт 400 гаруй хүн хамрагдлаа.

Соёлын чиглэлээр: Төрийн шагналт Ардын жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтан гадас одонт Хөгжимт драмын театр нь 39 үйл ажиллагаа зохион байгуулж нийт 97.500 үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлэн байгууллагын төлөвлөгөөний дагуу драм ангийн хамт олон инээдмийн баярын өдөрт зориулан “Хошин шог” тоглолтыг нутгийн зон олондоо өргөн барив. Мөн МУГЖ Б.Дугараагийн нэрэмжит “Алтан өв” бий биелгээний наадмыг 2 дахь жилдээ зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн Музей нь 2017 оны 04 дүгээр сард “ITM-2017” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов. Тус арга хэмжээнд 21 аймгийн 200 гаруй байгууллага, бизнес эрхлэгчид оролцож үйл ажиллагаагаа сурталчилсан бөгөөд аймгийн Музей энэ арга хэмжээнд үзэсгэлэн гаргаж сан хөмрөгийн үзмэрүүдээ дэлгэв. Сэргээн засварлах шаардлагатай 9 үзмэрийг бүртгэлээр соёлын өвийн төвд хүлээлгэн өгөв. Мөн “Нээлттэй хаалганы өдөр”-өөр салбарын байгууллагуудтай

хамтран цахим киоскоор мэдээлэл танилцуулан нийт 100 орчим хүнд үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулж буй “Хууль журам миний амьдралд” аяны хүрээнд аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдал”-ын хуулиар сургалт явуулж, нийт ажилтан албан хаагчдыг хууль эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэв.

Музейн хамт олон нь байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, үзэгчдийн ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор үзүүлэгийн танхим болон ажилчдын өрөө тасалгаануудад засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нийтийн номын сан нь 2017 оны 4 дүгээр сард 411 байнгын уншигч, 4463 ирцэд, 5531 ном, сонин сэтгүүл олгож үйлчиллээ. Энх тайвны корпусын сайн дурын ажилчидтай хамтран Access хөтөлбөрт хамрагдсан сурагчдын дунд англи хэлний эх хэлний асуулт хариултын тэмцээн зохион байгууллаа. Америк мэдээллийн төвийн 10 жилийн ой, монгол Америкийн дипломат харилцааны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ. Ойн арга хэмжээнд АНУ-с Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин Сайд Женифер Зимдал Галт, Улс төрийн хэлтсийн дарга Жеймс Моффит, Америкийн төвүүдийн захирал Болормаа болон аймгийн удирдлагууд англи хэлний мэргэжлийн багш нар, Энх тайвны корпусын сайн дурын ажилтнууд, Access хөтөлбөрт хамрагдсан сурагчид оролцов. Америкийн соёлыг сурталчлах 7 хоногийн аяны хүрээнд кино үдэш, Америкийн боловсрол сэдвээр лекц, Америкийн тухай ярилцья ярилцлага, англи хэлний олимпиад, дууны уралдааныг тус тус амжилттай зохион байгууллаа.

Нийтийн номын сангийн зөвлөн туслах ажлын хэсэг Манхан сумын соёлын төвийн номын санд фондын номын ээлжит тооллого хийх заавар зөвлөмж өгч ажиллав.

Ерөнхий боловсролын 12 жилийн ахлах 1 дүгээр сургуулийн номын санчтай хамтран 7 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол ардын тоглоом наадам ном хэвлэлийн хуудаснаа” сэдэвт өглөөлөг, “Ном уншихын ач тус” сэдэвт лекц, 6 цэцэрлэгийн хамт олонд “Үлгэрийн цаг” ном уншлагын арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулав.

Эрүүл мэндийн чиглэлээр: Жил бүрийн 04 дүгээр сарын 07-ны өдрийг “Дэлхийн эрүүл мэндийн өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. 2017 онд дэлхий нийтээрээ “Сэтгэл гутралын талаар хамтдаа - Ярилцья” уриатайгаар зохион байгуулав. Энэхүү өдрийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Дэлхийн эрүүл мэндийн өдрийг угтан зохион байгуулах үйл ажиллагааны удирдамжийг хүргүүлж дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 37 эмч, мэргэжилтэн нарыг “Ажлын байрны стресс ба сэтгэл гутрал” зайн сургалтанд хамруулснаар стресс ба сэтгэл гутралын талаар мэдлэгтэй боллоо. Төрсний дараах сэтгэл гутрал, цэвэршилтийн насны сэтгэл гутрал, өсвөр үеийн сэтгэл гутралын асуудлууд сэдэвт зайн сургалтууд хойшлогдож хугацаандаа болоогүй тул сумын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн нар хамрагдсангүй. Эрүүл мэндийн газрын Facebook хуудсанд сурталчилгааны гарын авлага байршуулж иргэдэд мэдээлэл түгээн ажиллаж байна.

Сумын эрүүл мэндийн төвүүд тайлангаа хугацаанд ирүүлж, тайлант хугацаанд 2200 иргэдэд сургалт сурталчилгаа хийж ажиллалаа. Аймгийн хэмжээнд сүүлийн 6 сард метилийн спирт ууж хэрэглэн амь насаа алдсан тохиолдол бүртгэгдээгүй, метилийн спиртийн хурц хордлогын эмчилгээ, оношилгооны талаар мэдээллийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.

Метилийн спиртийн хурц хордлогоос урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааг орон нутгийн Телевиз болон Facebook хаягаар олон нийтэд түгээж 1200 хүнийг хамрууллаа. Мөн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн <http://www.ncph.gov.mn/> цахим хаягаар орж “Метилийн спиртийн хурц хордлогоос сэргийлье! цуврал №1, №3” зурагт хуудаснуудыг татан авч сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хаягаар хүргүүлээ.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтэн нарт 5 сард “Метилийн спиртийн хурц хордлогын эмчилгээ, оношилгоо” сэдэвт сургалт хийхээр төлөвлөж байна. Өрхийн эрүүл мэндийн 5 эмчид 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр метилийн спиртийн хурц хордлогын эмчилгээ, оношилгооны талаар 2 цагийн сургалт зохион байгууллаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр Нийгмийн эрүүл мэндийн дэмжих жилийн хүрээнд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төвийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд жирэмсэн үеийн эрүүл зохистой хооллолт, архи тамхины хор хөнөөл, хөдөлгөөн эрүүл мэнд, нярайн асаргаа сувилгаа сэдэвт сургалтыг эрүүл мэндийн газрын сургалтын танхимд 2 өдөр 50 хүнийг хамруулан зохион байгууллаа. Энэхүү сургалтаар хүн амын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрүүл зан үйлд сургах, БЗДХ-аас сэргийлэх, жирэмсний хяналтанд орох ач холбогдол, эрүүл зөв дадлын талаар мэдээлэл түгээж иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлж өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэгтэй болголоо.

Сургалтын нээлт хийж, сургалтанд хамрагдаж байгаа оролцогчдоос мэдлэг үнэлэх үнэлгээг хийхэд сургалтын өмнөх мэдлэг 78%-тай байсан бол сургалтын дараах үнэлгээ 98%-тай болж оролцогчдын мэдлэг нэмэгдсэн үр дүн гарлаа.

“Нялхас бага насны хүүхдийн хооллолтыг гамшгийн үеийн арга хэмжээтэй уялдуулах” 3 хоногийн сургалтыг Булган, Алтай, Үенч сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт зохион байгууллаа.

Мөн өдрийн 192 дугаар албан бичгээр аймгийн боловсролын газарт Менингококт халдварын тухай сэрэмжлүүлэг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг хүргүүлж дараах ажлыг хийлээ.

“Менингококт халдвараас сэргийлэх шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 6 өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сумын Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагууд 6 өрх, БОЭТ, 9 сум менингококт халдварын талаар дотооддоо сургалтыг хийсэн байна. Орон нутгийн “Ховд” телевизээр илрэх эмнэлзүйн шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх аргын талаар сэрэмжлүүлэг явуулсан. Эмийн нөөцийн хувьд Цепрофлаксацин 100мг/10мл 138 ампул, 100мл- 38 флакон, 500мг №10 шахмал 576 ширхэг хэмжээтэй авахаар эм ханган нийлүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж, эхний улирлын эм нийлүүлэгдэж ирсэн байна. Нийт 3360 хүнд үзлэг хийснээс хамар залгиурын үрэвсэлтэй 225 хүн, үүнээс эрүүлжүүлсэн 173, амбулаториор 2705 хүн үзэж, хамар залгиурын үрэвсэлтэй 125 хүн, үүнээс эрүүлжүүлсэн 91, цэцэрлэгийн 897 хүүхэд үзлэг хийж хамар залгиурын үрэвсэлтэй 77, эрүүлжүүлсэн 58 хүүхэд байна. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн <http://ncph.gov.mn/> цахим хаягаар орж “Менингококт халдвараас сэргийлье!!! цуврал №1, №2” зурагт хуудаснуудыг татан авч өрхийн эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгүүдээр тараан түгээж байна. Менингококт халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Менингококт халдвараас сэргийлье” сурталчилгааны өнгөт 30ш материалыг хэвлэн ӨЭМТ-д хүргүүлэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллав.

Ховд, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан сумдын эрүүл мэндийн төвүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээг дархлаажуулалтын кабинетын үйл ажиллагаа, хамралт, зарцуулалт, вакцины орлого, зарлага, хадгалалт, тээвэрлэлт, вакцины устгал, хэрэглээ, анхан шатны бүртгэлийн маягтын хэрэгжилт, халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, ЭМС-ын 2016 оны А/93, 2014 оны 186, 187, 319, 358, 2011 оны 158 дугаар тушаал, сайдын албан даалгаварын хэрэгжилтийн явц, байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажиллав.

Олон улсын сувилагчдын өдрийг “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулъя” ажил мэргэжлийн уралдааныг сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд 2 үе шаттайгаар зохион байгууллаа. Нэгдүгээр шатны тэмцээнд Булган сумын нэгдсэн эмнэлэг, Мөст сум дундын эмнэлэг, Үенчийн цэргийн эмнэлэг сумдын 14 эрүүл мэндийн төвүүд нийт 17 эрүүл мэндийн байгууллагууд оролцлоо. Тус байгууллагуудыг 4 бүс болгон хувааж 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 4 сарын 21-ны өдрийн хооронд Дөргөн, Дуут, Зэрэг, Алтай сумдад сувилагч, багийн эмч, эх баригч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, вакцинатор, дүн бүтгэгч бага эмч гэх дараах 6 төрлийн мэргэжлээр бүсчлэн зохион байгуулж 102 эмнэлгийн сувилагч, тусгай мэргэжилтнүүд тэмцээнд оролцсон. Тэмцээн нь онолын мэдлэг шалгах сорил, ур чадвар сорих гардан үйлдэлийн тэмцээн болон тэргүүний туршлагаа хоорондоо танилцуулах гэсэн чиглэлүүдээр явагдаж Буянт, Дуут, Мөнххайрхан, Үенч, сумдын багууд багаараа дараагийн шатны тэмцээнд оролцох эрх авч мөн 6 мэргэжилээр орсон оноогоор тус бүр жагсааж эхний 4 байранд орсон шилдэг мэргэжилтэнгүүд тус тус шалгарч дараагийн шатны тэмцээнд оролцох эрх авч нийт 48 мэргэжилтэн 2-р шатны ажил мэргэжлийн уралдаанд оролцлоо.

Сувилагч тусгай мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан ажил мэргэжлийн уралдааны 2-р шатны тэмцээн 4 дүгээр сарын 24 Эрүүл мэндийн газарт зохион байгуулагдаж шилдэгүүдээ шалгарууллаа. Тус уралдаанаар мэргэжилтнүүд харилцан туршлага солилцож, мэдлэг чадвараа нэмэгдүүлэх, зэргийн шалгалтанд ороход бэлтгэх цаашид мэргэжлийн зэрэгтэй сувилагч, тусгай мэргэжилтнүүд нэмэгдэж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжрах ач холбогдолтой юм.

2017 оны 4 дүгээр сарын 3-нд Ховд, 4-нд Эрдэнэбүрэн, 5-7-ны өдрүүдэд Мөнххайрхан, 6,7-ны өдрүүдэд Дөргөн сумын Эрүүл мэндийн төв, 18-нд Буянт Эргэлтийн эмийн санд хяналт үнэлгээ хийж, зөвлөмжийг хүргүүллээ. Мөн Монос фарм ХХК-аас БОЭТ, өрхийн эмч нар болон эм зүйч эм найруулагч нарт 1 кредит бүхий сургалтыг хамтран зохион байгууллаа.

“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд Ховд аймгийн Эрүүл мэндийн салбарт ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын мэдээллийг ELEG.HINF.MN программд живж байгаа бөгөөд 4 сарын 24-ний байдлаар 50 хувийн хамрагдалтай байна.

Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан үйл ажиллагаа болон арга хэмжээнүүдийн талаар мэдээ, мэдээлэл, зар, халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлгийг [facebook /group/ 5](https://www.facebook.com/group/5), [facebook /page/](https://www.facebook.com/page/) хуудсанд 20 мэдээ мэдээлэл, зар болон, сэрэмжлүүлгийг байршуулан ажиллалаа. Мөн сумын ЭМТөвүүдтэй зайн хурал хийж байхаар төлөвлөсний дагуу 16 сум болон Булган өрхийн ЭМТөвүүдэд skype хаяг нээж камер, микропони авах санал хүргүүлж, сүлжээ холбогдсон 7 сум байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Хяналт шинжилгээ үнэлгээний 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 4 дүгээр сарын 3-7-ны өдрүүдэд Ховд, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан сумын эрүүл

газартай хамтран аймагт үйл ажиллагаа явуулж байгаа РС тоглоомын газруудын үйл ажиллагаанд 2017 оны 04 дүгээр сарын 05-06 ны өдрүүдэд хяналт шалгалт хийв. Тамхины хяналтын тухай хуулиар байгууллагын ажилтнууддаа сургалт зохион байгуулж, байгууллагын дэргэд хуулийн дагуу тамхи татах цэгтэй болов.

Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 4 кейст нөхцөл байдлын үнэлгээ хийн ажиллаж холбогдох байгууллагад зуучилж зөвлөгөө өгөв. Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу 1 гэр бүлийн гэрлэлт цуцлалт, хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчээр ажиллан дүгнэлтийг тухайн харъяалах шүүхэд хүргүүлэв.

Ховд, Эрдэнэбүрэн, Буянт, Мянгад, Дөргөн сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 300 гаруй сурагчдын дунд “Хүүхдийн хөдөлмөр, түүний хор уршиг”, “Цахим тоглоом ба дэлгэцийн донтолт” сургалт, хэлэлцүүлгийг 2017 оны 04 сарын 10-14-ны өдрүүдэд зохион байгуулж, хүүхдүүдийн өмнө тулгамдаж буй асуудлыг хүүхэд нэг бүрээр тодорхойлуулж хэлэлцүүллээ. Хүний эрхийн комиссын Ховд аймаг дахь ажилтантай хамтран Сүм, хийдэд шавилан сууж байгаа сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллав.

Дэлхийн улс орнууд болон Монгол улс жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ өдрийг тохиолдуулан хүүхэд бүрийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд хүчирхийллээс ангид өсөхөд олон нийтийн ойлголт, хандлага оролцоог нэмэгдүүлэх үүднээс гэр бүлийн радио FM 104.5, Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагын төлөөлөгчийн газрын “Хүүхдийн хөгжил хамгаалал” хөтөлбөр, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран “Би гэр бүлдээ үүнийг хүсдэг” гар зураг, шүлэг, зохион бичлэгийн улсын уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгууллаа. Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв зан үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн баримтлах чиглэлийг хуульчилсан байдаг тул үүнтэй уялдуулан аймгийн хүүхэд багачуудын эрхэмлэх зүйлийг боловсруулж ажиллав.

Хүн амын удмын санг хамгаалах “Угийн бичиг” хөтлөх ажлын хүрээнд салбарын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулж, нэгдсэн төлөвлөгөө гарган чиглэл өгч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Жаргалант, Эрдэнэбүрэн, Ховд, Буянт, Мянгад, Дөргөн сумын өрхүүдэд угийн бичиг хөтөлдөг болгож хэвшүүлэх, түүнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хариуцлагыг өндөржүүлэх хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллав.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдсан хуулиудыг практикт хэрэглэх арга зүйгээр хангах, эцэг эх, хүүхэд залуучуудад сурталчлах, хүүхдийн төлөө зөвлөл, хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, гэр бүл, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор 5 сумдад төрийн албан хаагчид, эцэг эхчүүдэд “Гэр бүл, нийгэм дэх хүүхдийн эрх хамгаалал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль”, “Аз жаргалтай гэр бүлийг бий болгох нь” сургалт, орон нутагт гэр бүлийн өмнө тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг хийж 600 гаруй иргэн хамрагдлаа. Оролцогчдоос гарсан саналыг нэгтгэн сумдын удирдлагуудад хүргэж цаашдын ажлын төлөвлөлтөнд тусган иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг ойртуулж ажиллах санал хүргүүлэв.

Хүүхдийн төлөө зөвлөлийн захирамжийн төсөл, гишүүдийн ажил үүргийн хуваарь, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргаар ахлуулсан аймгийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн дэд зөвлөлийн ажлын чиг үүргийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, хүүхдийн төлөөллийг оролцуулан 23 хүний

бүрэлдэхүүнтэй, Хүүхдийн төлөө зөвлөлийн Хүүхэд хамгааллын дэд зөвлөл 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулагдлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар салбарын хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд зүүн бүсийн 5 сумдын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан ажилтнуудын ажилтай танилцаж, Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажлыг 10 үзүүлэлтийн дагуу хянаж, үнэлгээ хийлээ.

2017 оны 04 дүгээр сард хүүхдийн эрх зөрчигдсөн 23 кейс бүртгэгдсэн байна. Кейсийн төрлөөр нь авч үзвэл гэр бүлийн орчинд бие махбоди, сэтгэл санааны шийтгэл 4, цахим мэдээллийн сувгаар бусдын нэр төрд халдсан 2, насанд хүрээгүй хүүхэд архидан согтуурсан 2, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 2, хурдан мориноос унаж нас барсан 1, хурдан мориноос унаж гэмтэж бэртсэн 2, ахуйн хүрээнд мориноос унаж нас барсан 1, хулгайн хэрэгт холбогдсон 3, эцэг эхийн хараа хяналт сул 2, сургуулийн орчин дахь багш нарын дарамт 1 ирсэн мэдээтэй байна.

Сумдад ажиллах явцдаа хүндрэлтэй шийдэх боломжгүй кейс үйлчилгээг бүртгэн авч орон нутгийн Хүүхэд хамгааллын хамтарсан багтай хамтран ажиллав. Аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 2 гэр бүлийн гэрлэлт цуцлалт, хүүхдийн асрамж тогтоолгох, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд ногдох хэсгийг гаргуулах, хүүхдүүдийн өсөж байгаа орчин нөхцөл, асран хамгаалалт, цаашид нэхэмжлэгч, хариуцагч нарын хэн нь хүүхдүүдийг асран хамгаалах боломжтой, хүүхдийн эрүүл мэнд, амар тайван, аюулгүй орчинд сэтгэл зүйд эерэгээр нөлөөлөхөөр өсөж торних баталгааг хангасан эсэх, хүүхдүүдийг хүчирхийлдэг эсэхэд дүгнэлт гаргахад шинжээчээр томилогдон ажиллаж байна. Энэ хүрээнд хариуцагчаас зохих зардлыг гаргуулах, хамтарч ажиллах байгууллагуудад шинжээчийн багийн ажиллах төлөвлөгөөг гарган хүргүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн сонирхол, эцэг эхчүүдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хэлний, уран бүтээлийн, урлагийн, ерөнхий эрдмийн хичээлийн 4 чиглэлээр 14 төрлийн дугуйланд хичээллүүлж 193 хүүхэд хамруулав.

Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: 2017 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 1.504.850.000 /төгрөг/-ийн санхүүжилт авснаас алдарт эхийн одон 1230.000.000, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 25.000.000, ахмадын “Насны хишиг”-т 249.850.000 санхүүжилтийг тус тус авсан байна. Орон нутгийн төсвөөс 2.363.396.100 төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагааг явуулж байна.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа 2017 оны 03 дугаар сарын 31-ны өдөр улс даяар албан ёсоор нээлтээ хийж эхэлсэн ба 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр хүртэл явагдаж дууслаа. Уг судалгаанд аймгийн хэмжээнд нийт 16596 өрх хамрагдснаас 16550 өрхийн судалгааг бүрэн авч 43 өрх судалгаа өгөхөөс татгалзав. Уг ажлын хүрээнд 4 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 79 тоологч, 13 шивэгч, 34 жолооч, 91 хөтөчийг хамруулан ажлын гэрээ байгуулан хамтран ажиллалаа.

2017 оны 04 дүгээр сард хүнсний эрхийн бичгийн цаасан болон цахим хэлбэрээр үйлчилгээ авдаг 811 өрхөд 50297000 төгрөгийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээгдэж байна. Судалгааны мэдээлэл цуглуулах явцад жагсаалтанд ороогүй өрхийг өргөдлийн аргын судалгаанд хамруулан аймгийн хэмжээнд жагсаалтнаас тусдаа 1600 гаруй өрхөөс өргөдөл хүлээн авч судалгаанд хамруулсан байна.

Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 03 дугаар сарын 27-ноос 04 дүгээр сарын 07-ний хооронд сумдын зорилтот өрхүүдэд хийгдэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж,

төлөвлөгөөний дагуу сургалтуудыг холбогдох банк санхүүгийн болон төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулав. Тус сургалтаар “Өрхийн хөгжлийн гурвалжин”-ийн үзүүлэлтүүдээр уулзалт, хэлэлцүүлгийг өрхийн суурь үнэлгээ, гишүүдийн хандлага, зан үйлийг өөрчлөх, эрүүл зөв амьдрах ойлголт, дадал хэвшлийг суулгах, гэр бүлийн боловсрол олгох, амьдрах орчингоо сайжруулах зэрэг хөдөлмөр, нийгмийн халамжийн салбар болон хамтран ажилладаг төрийн байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай уялдуулан зохион байгууллаа.

“Цагаан-уул” ахмадын сувилалд амарч буй ахмадуудын мэдээллийг халамжийн WAIS программд шивж олголтын жагсаалт бэлтгэн, амрагч ахмадад “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль болон “Ахмад настанд насны хишиг” олгож байгаа мэдээллийг өгөв. Жаргалант сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн хуралд оролцож хүнд нөхцөлд амьдарч буй 5 хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйн асуудлыг ярилцаж цаашид хамтран ажиллах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн 2017 оны ажлын гэрээний төслийг бэлтгэж, хянан салбар комиссын даргаар батлуулж төв комисст хүргүүлэв. Ортопедийн тусгай хэрэгсэл авах хэрэгцээтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрсийг халамжийн сангийн программд шалгаж 123 иргэнд ортопедийн туслах хэрэгсэл олгож wais программд бүртгэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиарилагдсан 2016 оны жилийн эцэст үүссэн өр төлбөрийн санхүүжилт 33.710.500, урьд онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 4.339.500 төгрөг эргэн төлөгдөж төвлөрсөн байна. Улсын төсвөөс 33.710.500 төгрөгийн санхүүжилт орсноос өмнөх оны өглөгт нийтийг хамарсан ажилд 17.577.600 төгрөг, ХБИ-ний ажил олгогчийн урамшилд 3.200.000 төгрөг, аж ахуй эрхлэлтийн сургалтад 6.270.000, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 6.660.000 төгрөгийн санхүүжилт хийлээ.

Тайлант сард нийт 54 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 800 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүллээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй 1773 ажилгүй иргэд байгаагийн 303 иргэнийг ажлын байранд зуучлан оруулсан байна. Шинээр бий болсон 35 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS санд орууллаа. 345 ажлын байрны захиалга ирж ажил хайгч иргэдээс 303 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Байнгын 137, улирлын 42, түр 124 ажлын байр байв.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөөнд 25 иргэн хамрагдав. 2017 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүд болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийн арга хэмжээ 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр болж тус арга хэмжээнд нийт 350 иргэд, аж ахуй нэгж байгууллага оролцов.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн ажилчид нь өөрийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийн хувиарын дагуу асаргаа сувилгаа, цэвэрлэгээ, хооллолт, олон нийтийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд таниулах, асруулагчдын хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргав. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулж албан хаагч асруулагч нарыг зөвшөөрөгдсөн цэгт тамхи татахыг шаардан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус сард асруулагчдын уух эм, тарианд 89260 төгрөг, хоолонд 2751600 төгрөгийг зарцуулсан байна.

Ахмадын сувилалын “Цагаан уул” цогцолборт Булган сумын 7 ахмад, Манхан 6, Жаргалант сум 13, нийт 30 ахмад настан амарч 297 ахмадын ор хоног 2,376,000 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллаа.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр:

Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газраас 2017 оныг “Эерэг хандлага-чанартай үйлчилгээ”-ний жил болгон зарласан. Энэ хүрээнд нийгмийн даатгалын 75 жилийн ойг угтаж “Чанартай үйлчилгээ-соёлтой харилцаа” 75 бүтээлч ажлыг өрнүүлэн ажиллав. Тус үйл ажиллагааг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын шийдвэрээр 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл 1 сар сунган бүтээлч ажил өрнүүлэн ажиллаж байна.

Тус хэлтэс нь тайлант сард 51 албан бичиг хүлээн авч 62 албан бичгийг холбогдох газарт хүргүүлж 12 өргөдөл гомдол хүлээн авч 5 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Архивын лавлагаагаар 461 даатгуулагч иргэдэд үйлчилж хэлтсийн сарын ажлын тайлан, мэдээг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж, цаг үеийн асуудлыг хэлэлцэн тодорхой шийдвэрүүд гарган биелэлтүүдийг тухай бүрт нь тооцон ажиллаж байна.

Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/35 дугаар тушаалаар тахир дутуу, тэжээгчээ алдсан иргэдийн тэтгэврийг банкны хүүгүйгээр урьдчилан олгож байна. Сайн дурын даатгалд 04 дүгээр сард 5300 даатгуулагчийн 345,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс эрүүл мэндийн даатгалын орлогод 2203 даатгуулагчийн 72,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэв.

БОЭТөвд 1320,0 сая, Мөст сумын эмнэлэгт 16,0 сая, Булган сумын эмнэлэгт 169,0 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөнд 190,0 сая төгрөг, 0-5 хүртэлх насны хүүхдийн эмийн үнийн хөнгөлөлтөнд 47,0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна. Тайлант сард 737 ажил олгогч 13008 даатгуулагч хамрагдаж, шимтгэлийн орлого 4,384 сая төгрөг төвлөрүүлэх тооцоотой байна. Өндөр насны тэтгэвэрт 7338 хүнд 5635818,5 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1488 хүнд 961800,2 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 775 хүнд 507562,3 мянган төгрөг, цэргийн тэтгэвэрт 205 хүнд 369247,9 мянган төгрөг, үйлдвэрийн ослын тэтгэвэрт 36 хүнд 145510,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 51 даатгуулагчид 57955775 мян төгрөг, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг 41 даатгуулагчид 3463113 мян төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 11 даатгуулагчид 28118811 мян төгрөг, 9 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 9,000,000 төгрөгийг тус тус олгож зарцуулсан.

Эх хүүхдийн магадлах комиссын ээлжит хурлыг 04 дүгээр сард 3 удаа хийж нийтдээ 365 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны асуудлыг хэлэлцэж 131 иргэний актыг сунгаж, 9 иргэний актыг цуцалж ажилласан төдийгүй 35 иргэний хугацааны актыг шинээр тогтоов. Энэ сарын байдлаар мэдээллийн баазад 3002 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Байгаль орчны талаар: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/12 дугаар тушаалын дагуу 2017 онд аймгийн 15 га талбайд шинээр ойн зурвас байгуулах “Ногоон хэрэм” төслийн хүрээнд ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажилд үнийн санал ирүүлэх урилгыг 9 аж ахуй нэгж, компанид хүргүүлж тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө 5 оролцогч материал ирүүлснээс Жаргалант суманд зарласан 5 га талбайн 1 дүгээр багцад “Сум дундын Ойн анги” Дарви суманд зарласан 10 га талбайн 2 дугаар багцад “Ховд сафори” ХХК, 3 дугаар багцад “Үр жимс” хоршоо тус бүр шалгарч гэрээ байгуулахаар ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-т холбогдох бичиг баримтуудыг хүргүүллээ. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачилгаар Монгол орны говийн зэрлэг амьтад болох хавтгай, мазаалай, тахь, хулан, монгол бөхөн, хар сүүлт тэдгээрийн амьдардаг экосистемийг хамгаалах зорилгоор “Говийн гайхамшигт 6” буюу “GG-6”

хэмээх арга хэмжээний хагас жилийн уулзалт 2017 оны 4 сарын 18-нд боллоо. Энэхүү уулзалтаар талууд хийсэн ажлаа ярьж харилцан туршлага солилцоноос гадна ирэх есдүгээр сард болох жилийн нэгдсэн уулзалт хүртэл хийх ажлаа төлөвлөв. Монгол бөхөнгийн тархац нутгийн зарим хэсгийг тусгай хамгаалалтад авах, түүхэн тархац нутагт нь сэргээн нутагшуулах чиглэлээр судалгаа хийхээр болж мөн хомын талын статусыг дээшлүүлэх, Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн газар нутгийг өргөтгөх, Тахь хамгаалах үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар батлуулах, Хавтгай, мазаалайн үндсэн амьдрах орчин болох Эхийн голын баянбүрдийг хамгаалах ажлын хэсэг байгуулж, санал боловсруулан, холбогдох газраар шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлэхээр болоод байна.

Мөнххайрхан, Булган сумдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Булган гол-Их онгогийн БЦГ-ын 2017-2020 онд хэрэгжүүлэх менежментийн ажлын төлөвлөгөөг дэлхийн байгаль хамгаалах сангаас санхүүжүүлэн 2017 онд боловсруулан гаргахаар төлөвлөсний дагуу эхний шатны хэлэлцүүлгийг 2017 оны 04 сарын 11-нд Булган суманд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хэсэгт хамгаалалтын захиргаа, Булган сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, орлогч дарга, Булган, Үенч, Бодонч голын сав газрын захиргааны ажиллагсад, Алаг толгой, Баянгол, Баянсудал багийн Засаг дарга, нутгийн иргэд нийт 55 хүн оролцов. Энэхүү менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь Булган гол-Их Онгогийн ТХГН-ийн бүсэд явагдаж буй байгаль-экологийн өнөөгийн хувирал өөрчлөлт, төлөв байдалд дүн шинжилгээ хийж, хэтийн чиглэл, зорилтуудыг оновчтой тодорхойлж, хүрэх үр дүн, арга зүйг бодитой төлөвлөж, нутгийн иргэдийн оролцоотойгоор хамтын байгаль хамгааллын тогтвортой менежментийг бий болгох, тухайн бүс нутаг дахь байгаль, түүх соёлын үнэт зүйлийг олон нийтээр хэлэлцүүлэн сонгож, эдгээр үнэт зүйлсэд учирч буй дарамт, аюул заналыг тодорхойлж, гарч буй шалтгааныг нь тогтоох, арилгах, авч хэрэгжүүлэх арга зам, ажлыг төлөвлөх хэлэлцүүлэх нь ёухал юм.

Хамгаалах шаардлагатай чухал үнэт зүйлсээр Ирвэс, Аргаль хонь, зэрлэг гахай, Минж, загас, Залаархаг хаварга /чийр/, Булган голын экосистем гэсэн 7 зүйл экосистемийг сонгож, төлөвлөлт хийв. Цаашид цуглуулсан мэдээ, материалыг үндэслэн менежментийн төлөвлөгөөний боловсруулалт хийж, 2 дахь шатны хэлэлцүүлэгийг 5 дугаар сард зохион байгуулахаар боллоо.

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”-өөр байгаль орчны салбарын байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцуулж, салбарын үйл ажиллагааг сурталчлав. “Дэлхийн усны өдөр”-ийг угтан байгаль орчны салбар байгууллагууд Ховд их сургуультай хамтран 4 дүгээр сарын 21-ний өдөр “Ус ба тогтвортой хөгжил-IV” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгуулж, илтгэлийн уралдаанд оюутнууд усны зүй зохистой хэрэглээ, тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, их нууруудын хотгорын ургамалжилт, усны чанар зэрэг асуудлаар хийсэн судалгааны ажлуудаар нийт 12 илтгэл тавигдлаа.

“Ховд аймгийн Дарви сумын нийгэм, эдийн засаг, экологи, байгалийн нөөцийн суурь судалгаа болон тогтвортой хөгжлийн төлөвлөгөө”-ний төслийг захиалагч тал Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын төлөөлөл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын захиргаа, аж ахуйн хэлтсийн дарга, сумын багийн Иргэдийн Хурлын төлөөлөгч, багийн Засаг дарга нар болон сумын иргэдийг хамруулсан хэлэлцүүлгийг Дарви сумын төвд зохион байгуулав. Тус арга хэмжээгээр Дарви сумын нийгэм, эдийн засаг, байгаль, экологийн суурь судалгааны танилцуулга, сумын тогтвортой хөгжлийн

төлөвлөгөөний төсөл, ногоон өргөмжлөлийн журмын төслийн танилцуулга зэрэг илтгэлүүд хөтөлбөрт багтан нийт 60 гаруй иргэд оролцож илтгэл хэлэлцүүлэгтэй холбоотой асуулт, хариулт, үнэтэй санал, шүүмж өрнөв.

Дарви, Чандмань, Дөргөн, Мянгад сумдын нутаг дэвсгэр болон Хар-ус нуурын байгалийн цогцолборт газар Монгол бөхөнгийн үхэл хорогдлын байдалд дүн шинжилгээ хийх, хадран загас, усны шувуудыг үржлийн үед нь хамгаалах, байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тухайн орон нутгийн иргэдэд байгаль орчны багц хууль тогтоомжийн холбогдох эрх зүйн хүрээнд сурталчилгаа хийх, хууль бусаар ан амьтан агнах барих, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авах зэрэг үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. Хяналт шалгалтанд хамрагдсан 200 гаруй иргэнд “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Амьтны тухай” хуулиудаар бэлтгэсэн зөвлөмж, сэрэмжлүүлэг гарын авлага тараав. Дарви суманд бөхөн 1658, хар сүүлтий 20, Чандмань суманд 1416 бөхөн, 4 хар сүүлтий нийтдээ бөхөн 3074, хар сүүлтий 24 бүгд 3098 бөхөн, хар сүлтийн сэг зэм цуглуулж устгаад байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны 93 дугаар дугаар албан бичигт заасны дагуу нэн ховор амьтан бөхөнгийн сүрэг, янгир ямаа, аргаль хонь зэрэг зэрлэг амьтдад бог малын гоц халдварт мялзан төст халдварт өвчин тархаж, нилээдгүй тоо толгойгоор хорогдсон бөгөөд өвчний голомт дарагдахгүй, халдвар авсан байж болзошгүй амьтад байршил нутгаа сэлгэх, өөрчлөх, голомтгүй газар нутагт дайжиж эрүүл бүсийн зэрлэг амьтдад өвчин тараах эрсдэл гарч болзошгүй байгаа тул тэдгээрийн бэлчээр нутаг, тархац, тоо толгой сүргийн бүтцэд тандалт судалгаа хийх зорилгоор Мөнххайрхан сумын Борт, Алаг багийн зэрлэг амьтдын бүс нутгуудад 3 ажлын хэсэг гарч ажиллав. Янгир ямааны 100 гаруй, Борт багийн Баянсайд аргаль хонийн 100 орчим бодгаль байсан бөгөөд тухайн популяцид мялзан өвчний шинж тэмдэг илрээгүй болно. Цаашид малчдад мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн буюу сүргээс ганцаар тасарч үлдэх, ноймоо болох, үргэж зугтахаа болих, баас алдах, нус гоожих зэрэг шинж илэрвэл яаралтай сумын Засаг даргын Тамгын газарт мэдэгдэх талаар зөвлөж, мялзан төст өвчний талаар гарын авлага тараах материал малчдад хүргүүлэн ажиллав.

Мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн мэргэжилтэн “Бөхөн” клубын сурагчидтай хамтран Манхан сумын ирвэс нутаглах байршил бүхий нутгууд болох Цанхиан эхэнд 2ш, Хөвчийн хойд нартад 1ш, Их Цахиртад 2 ш камер тус тус суурилуулав. Цэцэг, Дөргөн сумдад хууль бусаар алт олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж хуулийг сурталчлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Алтай, Булган сумдад бичил уурхай эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаанд хяналт хийж, ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, чулуун тээрэм багаж хэрэгслийг хураан авч ажиллалаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын аялал жуулчлалын холбоо хамтран “International Travel Mart – 2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 18 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, манай аймаг албан ёсны “Түнш” аймгаар оролцов.

Энэхүү үзэсгэлэнгийн зорилго нь төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийг уялдаа холбоог өргөтгөх, шинэ бизнесийн түнш олох, гэрээ хэлэлцээр хийх, бараа бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах зэрэг боломжуудыг олгож байгаагаараа онцлог юм. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөгжимт драмын театр, Аймгийн музей, Ховд их сургууль, Нийтийн номын сан, Мөнххайрханы байгалийн цогцолборт газар, Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 10 гаруй

аж ахуйн нэгжүүд нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож аймгийн музей ховор нандин үзмэрүүдээр үзэсгэлэн гаргаж, жуулчдад зориулсан аймгийн танилцуулгыг 2 ш киоскоор байрлуулан үзэсгэлэнд “2017 онд Ховд аймагт зохион байгуулагдах арга хэмжээний цаглабар” 1000ш, “Жуулчдад зориулсан аяллын газрын зураг” 3000ш хэвлүүлж олны хүртээл болголоо.

Аймгийн хэмжээнд Усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсүүдийг тогтоох ажлын санал боловсруулах хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Аймгийн ИТХурал болон ЗДТГ-ын удирдлагууд холбогдох салбар хариуцсан мэргэжилтэн төлөөллүүд оролцов. Хэлэлцүүлгийн үр дүнд усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсийг тогтоох ажлын удирдамж боловсруулж, уг ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгууллаа. Тус ажлын хэсэг шаардлагатай төсвийг тогтоон төсвийн төслийг аймгийн ИТХ-аар батлуулан 2017 онд багтаан хийж гүйцэтгэхээр болов.

Хаврын тариалалтаар мод үржүүлгийн талбайд тарьж ургуулах мөчрийг Буянт голын дагуух 1-2 настай улиасны мөчрийг шилэн авч тарьц суулгац хадгалах зориулалтын зооринд хадгалав.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: ХХААХҮЯам, Улсын мал эмнэлэг, үржлийн газарт малын зүй бус хорогдлын мэдээг цаг тухай бүр нь хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 1333,3 сая эх мал төллөхөөс 87,4 мянган мал төллөж, төллөлт 65,6 хувьтай, гарсан төл 86,1 мянга буюу 98,4 хувьтай бойжиж байна. Том малын зүй бус хорогдлоор нийт 12,1 мянган мал үүний 3,5 мянга нь хээлтэгч мал, өвчнөөр 36 мал хорогдсон дүн мэдээтэй байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Алтай, Булган, Буянт, Дарви, Зэрэг, Манхан, Мянгад, Мөст, Цэцэг, Чандмань сумдад тус бүр нэг, нийт 10 суманд 10 инженерийн хийцтэй худаг шинээр гаргахад ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2017 оны А/172 дугаар захирамжаар томилж, орон нутгийн зүгээс хяналт тавих “Зөвлөмж” боловсруулан сумдад хүргүүлэв.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх захиалгат шөвөг яр 350.0, ДХХ 1254.2 л, Колибактериоз 185.6 л, галзуу өвчний 61,1 тун, боом өвчний 34,7л, цусан халдвартын 854.2 л, дуут хавдрын 175 л, сахуугийн 650л нийт 110,1 сая төгрөгийн өртөг бүхий вакцинийг хүлээн авч хуваарьт сумдад олгон вакцинжуулалтын ажил 55,0 хувьтай хийгдэж байна. Өмнөх сард хийгдсэн стандартын хэрэгжилтийн дүнгээр үйл ажиллагаа явуулж байгаа 55 МЭҮН-ээс 37 МЭҮН буюу 67,3 хувь нь үзлэгт хамрагдаж, 18 МЭҮН буюу 32,7 хувь нь шалгалтанд хамрагдаагүй, 11 МЭҮН буюу 29,7 хувь нь 550-аас доош оноо авч “С” үнэлгээтэй стандартын шаардлага хангаагүй дүн үзүүлсэн буюу тэнцээгүй тул эдгээр МЭҮН-дэд хугацаатай үүрэг даалгавар өгч дахин шалгахгаар бэлтгэл хангуулан ажиллаж байна.

2017 оны 04 дүгээр сарын 25-ны байдлаар Чандмань, Дарви сумын устгалын цэгүүдэд 3072 толгой бөхөн, 24 толгой хар сүүлтий нийт 3096 толгой зэрлэг амьтдын сэг зэмийг цуглуулан устгав. Хүнсний захад 4180 кг махны 154 дээж, 1140 л сүүний 72 дээж, 500ш өлөнд МЭАЦ-н шинжилгээ хийж, 950 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийв. Мянгад сумын Гахайт багийн ямаан, Буянт сумын нарийн гол багийн үхрийн эмгэгт материалд нян судлалын шинжилгээ хийхэд халдварт өвчний үүсгэгч илрээгүй байна.

Аймгийн ХХААГ, Жаргалант сум, Дэлхийн Зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран тариаланчдад 8 цагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд нийт 69 газар тариалан эрхлэгч иргэд хамрагдаж, санал бодлоо солилцов. “Тариаланчдын улсын зөвлөгөөн”-д Буянт, Жаргалант сумын тариаланчдын төлөөлөл 5 хүнийг оролцуулав. Аймагтаа тариалан эрхлэгчдийн

зөвлөгөөнийг 04 дүгээр сарын 27-нд хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын дэмжлэг оролцоотойгоор зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Зам тээврийн чиглэлээр: Ховд АЗЗА компанийн хариуцдаг А0305 дугаартай Ховд-Баян-өлгий, А14 дугаартай Ховд-Манхан-Булган-Улсын хил, А0304 дугаартай Ховд-Алтай, А1701 дугаартай Ховд-Улаангом чиглэлийн улсын чанартай замуудад 2017 оны 04 дүгээр сарын 07-08-ний өдрүүдэд “Хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгаа”-ны ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: А0305 дугаартай Ховд-Баян-Өлгий чиглэлийг Хатуу хөтөлд, А14, А0304 дугаартай Ховд-Булган улсын хил, Ховд-Алтай чиглэлийг Манханы гурван замын уулзварт, А0304 дугаартай Ховд-Алтай чиглэлийг Бичигтийн хөтөлд, А701, А31 дугаартай Ховд-Улаангом, Ховд-Улиастай чиглэлийг Мянгадын гүүрний дэргэд тооллого хийв.

Тооллогоор: А14, А0304 дугаартай Манханы 3 замын уулзварт: Ховдоос Манхан-Булган-Улсын хил чиглэлд 58, Манхан-Булган-Улсын хилээс Ховдын чиглэлд 43, Ховд-Алтай чиглэлд 55, Алтайгаас Ховдын чиглэлд 67, А0305 чиглэлийн Хатуугийн хөтөлд: Ховдоос Өлгий чиглэлд 77, Өлгийгөөс Ховдын чиглэлд 67, А0304 чиглэлийн Бичигтийн хөтөлд: Ховдоос Алтай чиглэлд 119, Алтайгаас Ховд чиглэлд 96, А1701, А31 чиглэлийн Мянгадын гүүрний дэргэд: Ховдоос Улаангом чиглэлд 35, Улаангомоос Ховдын чиглэлд 32, Ховдоос Улиастай чиглэлд 15, Улиастайгаас Ховд чиглэлд 11 бүгд 675 тээврийн хэрэгсэл тоологдов.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын чиглэлээр: Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, зураг төсвийн байгууллага оролцсон салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, инженер техникийн ажилтнууд, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болох 30 гаруй төлөөллийг оролцуулав.

Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэрт “Сац гурван хайрхан” ХХК-ийн 22 айлын орон сууцны барилгын ажлын улсын комисс ажиллаж тус барилгыг ашиглалтад хүлээн авлаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас салбарын байгууллагуудыг оролцуулан зохион байгуулсан сарын аяны уулзалтанд оролцож, байгууллагын үйл ажиллагаа БМСШ-ны лабораторийг танилцуулж сурталчлав. Жаргалант сумын нээлттэй хаалганы өдөрт оролцож 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар өмчлөл, эзэмшил, газрын төлбөрийн танилцуулга хийж иргэдийн асуусан асуултанд хариулт зөвлөмж өгч ажиллав.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн аж ахуй нэгж байгууллагад үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар олгох нийт 7 байршилд газрын дуудлага худалдаа зарлаж, газрын биржид бүртгэлээ. Биржийн программд 23 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барьцаа бүртгэж үнийн мэдээг бүртгэв. Жаргалант сумын Засаг даргын санал, газар өмчлөх иргэдийн хүсэлтийг хүлээн авч хянан 11 иргэний газар эзэмших захирамж гаргаж, газар өмчлөлийг баталгаажуулан улсын бүртгэлд бүртгэв. Мөн газрын хэмжээ талбай хаягийн зөрчилтэй 17 иргэний зөрчлийг арилгаж, гэр бүлийн хэрэгцээнд хамтран газар өмчилсөн 1 өрхийн 4 иргэний газар өмчлөх эрхийг нээсэн. Газар эзэмших хүсэлт гаргасан 3 иргэний хүсэлтийг хүлээн авч гэрээ байгуулан гэрчилгээ олгов. Газар эзэмших, эрх шилжүүлэх гэрээ байгуулсан 3 иргэний хүсэлтийг хүлээн авч хянан эрхийг нь шилжүүлээд байна. Мөн 38 иргэний газрын кадастрын зураг гаргаж, иргэдийн асуусан асуултад хариу өгч иргэдэд иргэдэд төрийн үйлчиллээг хүртээмжтэй хүргэж ажиллалаа.

Хөрөнгө оруулалтын талаар: 2017 оны 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “ITM” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Баян-өлгий аймагт зохион байгуулагдсан Баруун бүсэд нэмүү өртөг бий болгох төслийн хөрөнгө

оруулагч нарын уулзалтанд аймаг орон нутгаа төлөөлөн оролцох ажлын хэсгийхэнд холбогдох гэрээ байгуулж тус арга хэмжээгүүдэд амжилттай оролцов.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар:

Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2016 оны тайланг Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ийн дагуу боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2014 оны А/595 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ хийх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу төрийн бус байгууллагуудын сонгон шалгаруулалтыг орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллээр дамжуулан 2017 оны 03 дугаар сарын 03-07-ны хооронд зарлаж, төрийн бус байгууллагуудад “Үнэлгээ хийлгэх тухай” албан бичиг хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээ хийх”-ээр Баруун бүс нутаг судлал, Ховдын толь, Тэргүүн танадалт, Ухаалаг хөгжил иргэдийн оролцоо төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн төслүүдтэй танилцаж сонгон шалгарууллаа. Төрийн бус байгууллагуудаас “Баруун бүс нутаг судлал” төрийн бус байгууллагыг шалгаруулж, гүйцэтгэх гэрээг аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулав. “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээ 2016” судалгааны тайланг гүйцэтгэж, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэлийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв.

Хэрэглэгчийн үнэлгээнд Булган, Дарви, Мянгад, Мөст, Ховд, Эрдэнэбүрэн сумд болон, Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний байгууллагууд болох Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Цаст-Алтай цогцолбор сургууль, VII сургууль, IY, VIII цэцэрлэгүүд хамрагдлаа. Төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжид өгсөн 2016 оны хэрэглэгчийн үнэлгээ 70.9 хувьтай дүгнэгдэж, өмнөх оноос 1.15 хувиар өссөн дүнтэй гарав.

Хэрэглэгчийн үнэлгээний тайланд тусгагдсан санал, дүгнэлтийн мөрөөр байгууллагуудын ажил, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө гаргаж, сум, байгууллагуудад зөвлөмж хүргүүлээд байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-ийн 2017 оны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх графикт оруулах саналыг хэлтсүүдээс авч нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2017 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх графикийг нэгтгэн гаргав. Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан болон хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн холбогдох материалуудаар 9 хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын архивын эрхлэгчид хүлээлгэн өгөв.

2017 оны 4 дүгээр сарын байдлаар Монгол улсын Засгийн газрын тогтоол 16, хуралдааны тэмдэглэл 4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 46 тогтоолыг тус тус хүлээн авч удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Долоо: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Төрийн байгуулалт, хууль эрх зүйн чиглэлээр:

2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

“Хууль журам-миний амьдралд” аяны хүрээнд “Тайван амгалан орчин бүрдүүлэхэд Иргэн миний оролцоо” аян өрнүүлж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Захиргааны ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад мэдээлэл өгч, сургалт зохион байгуулав. Харуул хамгаалалтын албатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх, манаач, сахиул нарын сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгүүдийн холбогдох албан хаагчдад 5 хоногийн сургалтыг зохион байгуулж, тэдний хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлж үнэмлэх олгов.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагдаагийн газартай хамтран төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан алба хаагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагын үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг Политехник коллежийн багш нар, Шим-Ус ХХК-ны ажилтнуудад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг сурталчлан таниулах, мэдээлэл хүргэх сургалт зохион байгуулж, сүүлийн өдрүүдэд гарч байгаа хэрэг, зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлж ажиллах талаар харилцан ярилцаж тэдний санал хүсэлтийг сонсов.

Нийгмийн бодлогын чиглэлээр: Бид нэг гэр бүл- Өрх бүрт мэндчилж байна” аяныг 2017 оны 04 сарын 17-ний өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 15-ний өдрийг хүртэлх 2 сарын хугацаатай өрнүүлж аяны хүрээнд багуудынхаа айл, өрх бүрээр орж тухайн өрх, иргэний мэдээлэл цуглуулах, амьдрал ахуйтай нь танилцах, судалгаагаа шинэчлэхэд түлхүү анхааран ажиллаж байна.

Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцан, хүүхдийн ирц, хоол хүнсний хадгалалт, хамгаалалт, сургалтын орчин, үйл явцтай танилцах ажлыг зохион байгуулав.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Мал сүргийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх график төлөвлөгөөт арга хэмнээний дагуу 600 бодод боомын, 1200 бод, бог малд галзуугийн, 1175 бог малд коли ижбалнадын вакцин, 2500 толгой малд туулгалт, 1120 толгой малд паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх туулга тарилгыг хийв. Халдварт болон гоц халдварт өвчнөөр өвчилж үхсэн малын сэг зэмийг устгалын 5 цэгийн координатыг тогтоон тэмдэгжүүлж зурагжуулав. Мөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран сумын “Газар тариалан эрхлэгчдийн сургалт, зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд тус сумын 69 тариалан эрхлэгчид хамрагдаж хүнсний аюулгүй байдал, хөрсний эрүүл ахуй, бордооны зөв зохистой хэрэглээний талаар чиглэл өгч, мэдээ мэдээллийг түгээв.

Газар зохион байгуулалт, дэд бүтцийн чиглэлээр: Сумын ИТХ-ын Төлөөлөгч нарт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар олголтын талаар

мэдээлэл өгч тэдний санал бодлыг сонсов. Мөн газрын цахим мэдээллийн сан, газрын харилцааны багц хуулиудын хүрээнд хийгдэж байгаа ажил, хуулийн хэрэгжилтийн талаар багийн Засаг дарга нар болон нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулав. Жаргалант сумын нээлттэй хаалганы өдрөөр газрын тухай хууль, хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сурталчлан 180 иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгөв. 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 7 байршилд дуудлага худалдаа зохион байгуулах бэлтгэл ажил хангагдаад байна.

Чандмань сум: Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа 03 сарын 31-ний өдрөөс 04 сарын 10 хүртэлх 10 хоногийн хугацаанд явагдаж судалгаанд хамрагдах өрхийн жагсаалтад орсон 563 өрхийг бүрэн хамруулав. 2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын ажиллагааг 04 сарын 19-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Сумыг Засаг даргын нэрэмжит “Оюун ухааны наадам”-ыг зохион байгуулж шилдэг анги хамт олныг шалгаруулан Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулав. Доктор, профессор нэрт сурган хүмүүжүүлэгч С.Мягмарсүрэн агсны нэрэмжит орчин үеийн физикийн хичээлийн лабораторийн нээлтийн ёслолын үйл ажиллагаа болж багш, сурагчдын физикийн хичээл сурах нөхцөл бололцоогоор бүрэн хангагдсан үр өгөөжтэй бүтээлч ажил боллоо.

Сумын хэмжээнд 118179 хээлтэгч эх мал төллөхөөс 63965 мал төллөж төллөлт 54,1%тай байна.

Жаргалант сум, Дарви, Зэрэг сумдын цэцэрлэгийн бүсийн чуулганыг 4 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулж, сайн туршлагаа хуваалцан спорт урлагийн арга хэмжээ болов, Тус арга хэмжээнд 5 цэцэрлэгийн 70 багш, удирдлагууд оролцов.

Мөст сум: Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, сумын эрхлэгч их эмч нар хамтран өрх бүрээр орж амьдрал ахуйтай танилцан тэдний санал бодлыг сонсов. Сумын нэгдсэн халаалтын шугам сүлжээний судалгааны ажил хийгдлээ. Аймгийн шүүх болон Булган сумын сум дундын шүүх, прокурорын газраас 2016 оны ажлын тайлан, 2017 онд хийж хэрэгжүүлэх төлөвлөсөн ажлаа танилцууллаа. Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийнхэн хяналт, шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Санхүүгийн ажил 63,2 хувьтай шалгагдлаа. Хаврын эхний ээлжийн цэрэг татлага явагдаж 53 залуус цэргийн зарлан авснаас 5 тэнцэж бусад нь хойшлогдов. Дүйцүүлэх албаны 4 цэрэг орон нутагт алба хааж байгаагаас ээлжит ажлаа төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Эдийн засаг төсөв санхүүгийн чиглэлээр: Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээг праграммд баталгаажуулав. Сумын нэгдсэн санхүүжилтээр 621581,4 мянган төгрөгийн орлого авч 597814,5 мянган төгрөгийн зарлагатай 23766,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

04 дүгээр сарын байдлаар 8592,0 мянган төгрөг төвлрөхөөс 4177,1 мянган төгрөг төвлөрч 49,3 хувьтай байна. Энэ нь суутгагчийн хувь хүний орлого, үйл ажиллагааны орлого төлөвлөгөө өндөр тогтсонтой холбоотой.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 2 даатгуулагч шинээр хамрагдсан ба нийт 38 даатгуулагчийн 2027,9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 23 даатгуулагчийн 813,5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 9 байгууллагын 20380,9 мянган төгрөг, нийт 23221,9 мянган төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 91 хувьтай байна. 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 99583,8 мянган төгрөг, тэтгэмжид 289,4 мянган төгрөг, нийт 99873,2 мянган төгрөг тавьж олгосон төдийгүй тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 5 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 2 даатгуулагч тэтгэвэр тогтоолгов. Тэтгэврийн өөрчлөлтийг ажилласан жилийн хуулийн дагуу 1 тэтгэвэр авагч хийлгэсэн байна.

Улсын бүртгэлд шинээр төрсөн хүүхэд 5, шинээр гэр бүл болсон 1, овог нэрээ сольсон 1, шилжиж ирсэн өрх 2, шилжиж явсан өрх 1, иргэн 11 тус тус бүртгэв. Нийгмийн халамжийн сангаас 41 ХБИ сар бүр 140000 төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмж 12, хүүхэд, ахмад настны асаргаанд 60 хүн, ХБИ-ний асаргаанд 18 хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаанд 10 хүүхэд, бүтэн өнчин буюу асрамжинд байгаа 3 хүүхэд, 16 дээш насны эм тарианы үнэ ХБИ 10, ахмад настан 19, 16-аас доош насны эм тарианы үнэ 10 хүүхэд 140000 мянган төгрөгийг тус тус авч халамжаас авсан байна.

Нийслэлээс 1000 ба түүнээс км алслагдсан байнга оршин суудаг ахмад настан аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардалд 1 хүнд 65000 төгрөгийн хөнгөлөлтийг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.

Тайлант сард 1 ахмад настныг 11500 төгрөгийн шүдний хөнгөлөлтөнд хамруулсан байна. Асаргаанд орох хүсэлтэй 5 иргэний өргөдөл ирсэнээс амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар 3 өргөдөл шийдвэрлэгдэв. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 519 өрх хамрагдахад 1 өрх татгалзаж 518 өрх хамрагдаж, нэмэлтээр 83 өрхийн судалгаа авах байснаас 103 өрхөөс мэдээлэл цуглуулж сумын нийт дүнгээр 620 өрхийг хамрууллаа.

Сумын хэмжээнд төл бойжилт, малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоног бүр мэдээлж, мал төлөлт 62%-тай байна.

Сумын эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг 356 үзүүлснээс алсын дуудлага 15, амбулатор 121, урьдчилан сэргийлэх үзлэгт 141, гэрийн идэвхтэй эргэлт 21, вакцины хамралт 95%, жирэмсний хяналт 6, хэвтэж эмчлүүлсэн 30, гэрийн дуудлага 28 байв.

Цэцэг сум: Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хөшөөт төслийн хүрээнд ажиллаж буй тээврийн компаниудын ажил байдалтай танилцан, орон нутагтай хэрхэн хамтарч ажиллах тухай санал бодлоо солилцлоо.

Сумын төвийн ногоон байгууламжийг ЛюДиВан, Ундрам алт ХХК-ны усны машиныг ашиглан төвийн ногоон байгууламжид усалгаа хийж орон нутгийн өнгө үзэмжийг сайжруулахад анхааран ажиллаж байна.

Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн групп шалгалт тус сумын төрийн сан, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, тайлан гаргалт, анхан шатны бичиг баримт болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Аж ахуйн нэгжүүд тайлан гаргалтын талаар нэгдсэн ойлголттой болж санхүүгийн алба олон улсын нягтлан бодох секторын болон нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу ажиллах, зөрчил дутагдалаа давтахгүй байх тал дээр цаашид анхаарч ажиллах чиглэл өглөө.

2017 оны 1 дүгээр ээлжийн Цэрэг татах ажиллагаа тус суманд зохион байгуулагдаж цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах хуудас авсан 32 иргэн Цэрэг татлагын комиссоор орж, 7 иргэн цэргийн жинхэнэ албанд тэнцэж, 4 иргэн дүүцүүлэх албанд бүртгэгдэж, бусад иргэд нь хуулийн хүрээнд шийдвэр гаргууллаа.

Сургуулийн нийт сурагчдын дунд “Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг” гар зураг, зохион бичлэг, шүлгийн уралдааныг зохион байгуулж, уралдаанд ирүүлсэн хүүхдүүдийн бүтээлээр дамжуулан хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчинг бүрдүүлэхэд эцэг эхчүүдийн ойлголт хандлагыг өөрчлөх, гэр бүл хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болж нийт хүүхдүүдийн бүтээлээр үзэсглэн гаргав.

Оаеёааí ò õããõààí ä сумын Çаŋаg даргын Тамгын газарт нееò 35 àеáаí àе÷еä èðŋí ýŋñ õõãõààòàе 20 àе÷еä èðж õõãõààí ä í ü õî èáí ää õ äãçàðò уламжилж

хүргүүллээ. Байгууллага иргэдийн 8 өргөдөл, гомдол ирсэнийг бодож өгөх хариуг бүрэн шийдвэрлэв.

Хөшөөт багт Эрүүл мэндийн төвийн нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж 95 иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулж халдварт бус өвчний эрт илрүүлгийн хувь өсөж хүмүүсийн оролцоо сайжирч эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж сургалтын гарын авлагыг тараан ажлаа сурталчлав.

Туршлага солилцох бүсийн сайн үйл ажиллагаанд багаараа амжилттай оролцож 2 дугаар байр эзэллээ. 6 сумын 49 багш сайн туршлагаас суралцаж хамтран ажиллаа.

Сумын Эрүүл мэндийн төв, сургуулийн эмч нар хамтран хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах зорилгоор шүдний үзлэгийг шат дараалан зохион байгуулж шүдээ хэрхэн зөв арчлах сургалт өгч ажиллаа.

Сар бүр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад соёл хүмүүжлийн сургалт хэлэлцүүлэг, уралдаан тэмцээнийг холбогдох албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулж сурагчдын идэвхи санаачлагыг дээшлүүлэх, тэдний дуу хоолойг сонсох, хүргэх үр дүнтэй бүтээлч үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулж тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хүргэлээ .

Булган сум: Сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд 2017 оны 04 дүгээр сарын 06-нд сумын удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнөөр суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдлагууд хүрэлцэн ирж цаг үеийн тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо солилцон зөвлөлдөж ажлын чиглэл гаргав. Удирдах ажилтнуудын зөвлөгөөнөөс 04 дүгээр сард төрийн албан хаагчдыг эмнэлгийн үзлэгт хамруулах, угийн бичиг хөтлөх, бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулахаар шийдвэр гарч, шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор тодорхой бодит ажлууд хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.

Аж ахуй нэгж төсөвт албан байгууллагуудад “Нийтийн эзэмшлийн талбайг хариуцуулах тухай” сумын Засаг даргын 2016 оны А/195 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах үүрэг чиглэл өгч, сумын ЗДТГ-аас хяналтын ажлын хэсэг томилогдон удирдамжийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээг шуурхай хүртээмжтэй зохион байгууллаа. Тус арга хэмжээнд суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага аж ахуй нэгж, иргэд, сургуулийн сурагчид идэвхитэй оролцов. Энэ үеэр 6 машин хог хаягдлыг цэвэрлэн төвийн бүсийн цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэн ажиллаа. Цаашид сар болгоны нэг өдрийг бүх нийтийн цэвэрлэгээний өдөр болгох шийдвэр гаргалаа.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг 2017 оны 03 сарын 31-нээс 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдан явагдаж судалгаанд 2 ахлагч, 9 тоологч, 9 хөтөч ажиллан 1975 өрхийг судалгаанд хамруулан ажиллаа.

“Өрхийн тэргүүн Түшигтэй аавууд” аавуудын зөвлөгөөнийг баг тус бүр зохион байгуулан ажиллаж байна. Зөвлөгөөний үеэр ахмадуудын үгийг хойч үед нь сэдэвт яриа өрнүүлсэнээс гадна өнөөгийн залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо солилцов.

Сум дундын Прокурорын газраас 2016 онд хийсэн ажлын тайлан болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг сумын нийт 70 гаруй иргэд, хөдөлмөрчид болон төрийн албан хаагчдад танилцууллаа. Сумын Засаг даргын 2017 оны А/33 дугаар захирамжийн дагуу “Хууль журам миний амьдралд” аян өрнүүлж, тус аяны хүрээнд иргэд, төрийн албан хаагчдад Үндсэн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний тухай хуулиудыг сурталчилан мөрдөж ажиллах чиглэл өгч ажиллаа. Гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх, гарсан хэрэг зөрчлийг цаг алдалгүй шуурхай илрүүлэх зорилгоор сумын төвийн бүсийг бүрэн камержуулав.

Сумын Иргэдийн Хурлын төлөөлөгч Д.Ууганжаргал “Оюунлаг Минжит Булган” хөтөлбөрийн хүрээнд номын аян өрнүүлж 1100 гаруй ном цуглуулан сумын номын сангийн фондыг баяжуулан хандивлалаа. 2017 оны 04 сарын 07-ны өдөр Ардын боловсролын тэргүүний ажилтан Цэвгээгийн Баатаржав агсны нэрэмжит “Дүрслэх урлаг, дизайн техник тохнологийн VII” олимпиадыг “Минжит Булган” цогцолбор сургуулийн Авъяас хөгжүүлэх секцээс санаачлан Булган өгөөж ХК-ны захирал Б.Мөнхтөр, Ц.Баатаржав агсны гэр бүл үр хүүхдүүд нь ивээн тэтгэж зохион явууллаа. Тус олимпиадад Алтай, Үенч, Мөст, Булган сумын 12 жилийн 1 дүгээр сургуулийн 600 гаруй сурагчид өөрсдийн хийсэн гар эсгий урлал, хайчилбар, сийлбэр, авто загвар, усан загвар, уран зураг, зураг зүй, технологи эрэгтэй, эмэгтэй гэсэн төрлүүдээр амжилттай оролцож, нэгдсэн дүнгээр Алтай сумын 12 жилийн дунд сургууль 1 дүгээр байр, Булган сумын “Минжит Булган” цогцолбор сургууль 2 дугаар байр, Булган сумын 12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургууль 3 дугаар байр эзэлж шалгарлаа.

Баруун бүсийн цэцэрлэгүүдийн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх “Сайн үйл ажиллагаа” зөвлөгөөнд оролцож багийн дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн амжилт гаргалаа. 12 жилийн 1 дүгээр сургуулиас Г.Ядамсүрэн багшийн нэрэмжит “Монгол хэл бичгийн” баруун 3-н сумын олимпиад, Ш.Бадам багшийн нэрэмжит Химийн олимпиад тус тус амжилттай зохион байгуулагдав. Бүрэнхайрхан боловсрол сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Физик, Англи хэлний олимпиадад Минжит Булган цогцолбор сургууль, Булган сумын 1 дүгээр 12 жилийн бүрэн дунд сургуулийн сурагчид амжилттай оролцлоо.

Сумын Эрүүл мэндийн төв нь явуулын пост ажиллуулан сумын төвөөс алс орших иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тогтмол үзүүлж, 3 заставын 300 гаруй иргэд, албан хаагчдад үзлэг, оношилгоо хийв.

Мерси Кор Монгол Олон улсын байгууллагын санхүүжилтээр сумын төвд өвс тэжээлийн фонд барих, Алагтолгой багийн нутаг дэвсгэрийн гүний худгийг засварлаж сайжруулан сэргээх ажил хийгдэж байгаа бөгөөд уг ажлын гүйцэтгэл явцтай USAID-ын төлөөлөгчид танилцаж заавар зөвлөгөө өгөв.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/133, дугаар захирамжийн дагуу 2017 оны 1 дүгээр ээлжийн Цэрэг татах ажиллагаа тус суманд 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах хуудас авсан 55 иргэн Цэрэг татлагын комиссоор орж, 24 иргэн цэргийн жинхэнэ албанд тэнцэв.

Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн 4 дүгээр сарын 27-ны өдөр болж, Тус зөвлөгөөнд 90 гаруй газар тариалан эрхлэдэг иргэд оролцож санал бодлоо солилцсоны эцэст Сум хөгжүүлэх сангын эргэн төлөлтийн төсвөөс газар тариалан эрхлэгчдийг түлхүү дэмжих, Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнийг 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж байх, Газар тариалан эрхлэгчдийг бүлэг болгон ажиллуулах, Усны эх гаргахад төр иргэний хамтын оролцоог тэлж нэмэгдүүлэх, Газар тариалан эрхлэгчдийн хийсэн ажлыг жилийн эцэст бодитоор дүгнэх шийдвэрүүд гарлаа. Газар тариалан эрхлэгчид болон иргэд өөрийн эзэмшилд буй тор, хашааны дотор дайран өнгөрч буй суваг шуудууг сэргээж засварлаагүй тохиолдолд 1 метрийг 1000 төгрөгөөр үнэлж, тодорхой ажил, хөдөлмөр эрхлэдэггүй иргэдээр гүйцэтгүүлэх, хэрэв засварлуулаагүй тохиолдолд торыг нь хураан авах зэрэг арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.

Үенч сүм: Сумын ЗДТГ болон төсөвт албан байгууллагууд, аж ахуйн нэгж, ард иргэдийг бүрэн хамруулсан бүх нийтийн цэвэрлэгээний арга хэмжээг зохион

байгуулж, хог хаягдлыг ачиж хогын цэгт зайлуулав. Албан байгууллагуудын гаднах орчинг бүрэн камержуулах томоохон ажлыг хийж гүйцэтгэв.

Малын эрүүл мэнд хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нар хамтран суманд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийж, Хятад улсын хилээр гаргахыг хориглосон, хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч байцаагчийн 21/02/316/01 тоот актаар устгал хийв.

Газар тариалангийн ажил эхэлж байгаатай холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор тариалалтын талбайд чацаргана, жимс жимсгэний суулгацыг бэлтгэж услав. Газар тариалан эрхэлж хүнсний ногоо тариалах хүсэлтэй иргэдийг дэмжиж үр тариаг нь Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгож, туслах аж ахуй эрхлэхийг хүссэн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд газар эзэмшүүлж, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг төсөвт албан байгууллагуудын ажил байдалтай танилцаж албан хаагчидтай уулзалт хийв.

Мэргэжлийн хичээлийн олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид амжилттай оролцож монгол хэлний хичээлийн олимпиадад 12 дугаар ангийн сурагч Б.Оюунгэрэл 1 дүгээр байр эзэлж алтан медаль, улсад 3-ын даваанд оролцох эрхийн бичгээр, 12 дугаар ангийн сурагч Н.Золзаяа 4 дүгээр байр эзэлж мөнгөн медаль, ХоИС-д 70%-ийн тэтгэлэгтэй суралцах эрхийн бичгээр, Физикийн хичээлийн олимпиадад 8 дугаар ангийн сурагч С.Буянзаяа 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, Газар зүйн хичээлийн олимпиадад 12 дугаар ангийн сурагч С.Нурболат 5 дугаар байр, ХоИС-ийн олимпиадад 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, 12 дугаар ангийн сурагч Б.Сундуйжав 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль, Эрүүл мэндийн хичээлийн олимпиадад 8 дугаар ангийн сурагч Э.Отгонхишиг 4 дүгээр байр, ХоИС-ийн математикийн хичээлийн олимпиадад 7 дугаар ангийн сурагч Д.Сүлд-Эрдэнэ 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, ХоИС-ийн биологийн хичээлийн олимпиадад 12 дугаар ангийн сурагч Б.Тэнгис 5 дугаар байр эзэлж ХоИС-д суралцах эрхийн бичгээр тус тус шагнагдав.

Багш Д.Ариунбаяр англи хэлний хичээлийн олимпиадад орж 2 дугаар байр эзлэн мөнгөн медаль, багш Д.Армянбек технологийн хичээлийн олимпиадад орж 3 дугаар байр эзлэн хүрэл медаль, багш Б.Мөнхбат зураг,дизайны хичээлийн олимпиадад орж 3 дугаар байр эзлэн хүрэл медалийг тус тус хүртсэн амжилтуудыг үзүүллээ.

“Сайн хичээл”-ийн бүсийн зөвлөгөөнд сургуулийн захирал, сургалтын менежерүүд болон бага, дунд ангийн 24 багш нар оролцлоо. Булган сумын Минжит Булган цогцолбор сургууль дээр 4 дүгээр сарын 08-нд бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан н.Баатаржав агсны нэрэмжит “Зураг зүй, дизайн”-ны хичээлийн олимпиадад сурагчид амжилттай оролцов. Үүнд: Зураг зүйн багш Б.Мөнхбатын бэлтгэсэн “Уран зураг”-ийн төрлөөр 9-а ангийн сурагч А.Буяннэмэх 1 дүгээр байр эзэлж, алтан медаль, 9-а ангийн сурагч С.Баярсайхан 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, 8-а ангийн сурагч А.Лхагва тусгай байр, 11-а ангийн сурагч С.Буянхишиг 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, 11-б ангийн сурагч А.Тулга 4 байр, 5-а М.Баясгалан тусгай байр, технологийн багш Д.Армянбекийн бэлтгэсэн 6-а ангийн сурагч Б.Сарангуа 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль, 6-а ангийн сурагч Б.Үүрцайх 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, Л.Чинзориг тусгай байр, технологийн багш Л.Даваажаргалын бэлтгэсэн 12-б ангийн сурагч Б.Оюунбилэг 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль, бүтээлийн төрөлд 11-б ангийн сурагч Б.Оюунжаргал 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль

Спортын “Бага олимп”-д төрөл тус бүрээр оролцож нэгдсэн дүнгээр 6 дугаар байр эзэлж, 33 сурагч спортын 6 төрөлд /Гар бөмбөг, сагсан бөмбөг, шатар, даам,

теннис, хөнгөн атлетик/ амжилттай оролцсноос Биеийн тамирын багш С.Батжаргалын дасгалжуулсан “Гар бөмбөг”-ийн төрлийн эмэгтэй баг тамирчид 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль, дунд насны шатрын төрөлд 8-в ангийн сурагч Ө.Ундраа тусгай байр, багш Э.Мөнгөнцэцэгийн бэлтгэсэн 800 м-ийн гүйлтийн төрөлд 11-б ангийн сурагч Н.Ариунболд 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль тус тус хүртсэн амжилт үзүүллээ.

3 дугаар улирлын амралтаар багш, ажилчид сонирхолоороо нэгдэж 5 хүн нэг баг болж 12 багаас 16 төрлийн бүтээлч ажлаар сургуулиа тохижуулах 14 хоногийн аяныг зохион байгуулж гүйцэтгэлээ.

Сумын Эрүүл мэндийн төв нь 04 дүгээр сарын 5,6-ны өдрүүдэд цэцэрлэг, сургууль, Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, ХААН банкны албан хаагчдад урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг хийж “Элэгний В,С вирус”, “Халдварт бус өвчин”, “Менингококкт халдвараас сэргийлэх” сургалтыг зохион байгуулж тэдний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэв. Эрүүл мэндийн салбар зөвлөл хуралдаж 2 дугаар улирлын ажлын төлөвлөгөө, “Шилдэг эрүүл мэндийн салбар зөвлөл” шалгаруулах уралдааны болзол, Эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажиллах журам боловсруулах төсөлтэй танилцаж, хэлэлцэн шийдвэрлэв.

Алтай суманд зохион байгуулагдсан баруун 3 сумын сувилагч, тусгай дунд мэргэжилтнүүдийн “Ажил мэргэжлийн уралдаан”-д багаараа амжилттай оролцож 1 дүгээр байр эзлэн аймагт болох ажил мэргэжлийн уралдаанд оролцох эрхийн бичгээр шагнуулж, багаараа 3 дугаар байр эзэллээ. Норвегийн тусламжийн байгууллагын хяналт үнэлгээний шалгалтын баг хяналт үнэлгээ хийж ажилд үнэлгээ өглөө.

Эрдэнэбүрэн сүм: “Хууль-журам миний амьдралд” аяны хүрээнд сумын Засаг даргын 2017 оны А/21 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан удирдамж, ажлын төлөвлөгөө, ажиллах график гаргаж нээлтийн үйл ажиллагааг 4 дүгээр сарын 6-ны өдөр хийж 60 иргэд оролцлоо.

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан төлөвлөгөөний дагуу сумын төрийн албан хаагч, байгууллагад төрийн албан хаагчдын мөрдөх “Ёс зүйн эрхэмлэх мөрдлөг”-ийг батлав.

Ерөнхий боловсролын 8-10 дугаар ангийн сурагчид, төрийн албан хаагч иргэдэд Эрх зүйн ажилтан Ш.Энхжаргал Тамхины хяналтын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Захиргааны ерөнхий хуулиар, Төрийн сангийн мэргэжилтэн Б.Хишигтогтох Төсвийн тухай хуулиар, Иргэний бүртгэлийн тухай хуулиар, Улсын бүртгэгч Н.Цэвэлмаа, Байгаль хамгаалах тухай хууль, Ойн тухай хуулиар БОХ-ын байцаагч Х.Мөнхжаргал нар сургалт зохион байгуулж тайлант хугацаанд хийсэн ажлын тайлан, мэдээлэл хийв.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/133 захирамжын хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын 2017 оны А/30 захирамж гарган, цэрэг татлагын ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр сумын хэмжээнд зохион байгууллаа. Цэргийн нэгдүгээр ээлжийн цэрэг татлагад нийт 23 цэргийн насны иргэн оролцож, 9 залуу тэнцэж, 8 залуу дүйцүүлэх цэргийн албанд хамрагдаж, 6 залуу эрүүл мэндийн шалтгаанаар хойшлогдов.

Загасны үржлийн үед байгаль орчны багц хууль, Ан амьтны тухай хуулийн хүрээнд мэдээлэл бэлтгэн иргэдэд ухуулга, сурталчилгаа хийж сумын удирдамжын дагуу байгаль хамгаалагч П.Гантөмөр, цагдаа д/а Б.Нямдорж нар Шижигтийн хавцалд 14 хоногийн хугацаанд байнгын постонд хяналтаар ажиллав.

ИТХ-ын төлөөллөгчид “Малчиддаа туслая” аян өрхүүлж, малчидтайгаа уулзан санал хүсэлтийг хүлээн авч холбогдох мэдээллийг өгч ажиллав.

Нийслэл болон Дархан, Эрдэнэтийн нутгийн зөвлөлийг шинэчлэн сум орон нутгийн хөгжилд нутгийн иргэдийн санал санаачилга тэдний оролцоог нэмэгдүүлэхэд анхааран хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Долоо хоног бүрийн пүрэв гарагийг “Бүтээн байгуулалтын өдөр” болгон нийтийг хамарсан ажил үйлчилгээг зохион байгуулж, суваг шуудууг сэргээн засварлав. Сумын соёлын төвд тайлант хугацаанд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нээлттэй хаалганы өдөр, АХА тэмцээн, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сургалтууд болон “Хосоороо” аялан тоглолт нийтийг хамарсан 4 томоохон ажил зохион байгуулагдаж 311 иргэд, 102 хүүхэд тус арга хэмжээнүүдэд оролцов.

Сумын Эрүүл мэндийн төвийн амбулаториар 156 иргэн үзлэгт хамрагдаж, дуудлага 18, жирэмсэний эхний 3 сартай хяналтанд 4 эхийг хүлээн авч иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг тухай бүр нь шуурхай үзүүлж байна. Төвийн бүсийн сумдын сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүдийн тэмцээнд 8 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцов. Мөн сургуулийн 248 хүүхдэд аймгийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүд урьдчилан сэргийлэх үзлэг хийв. “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд В,С вирус илрүүлэх шинжилгээнд 62 иргэнийг хамруулав.

“Сайн хичээл” үйл ажиллагааны 1 дүгээр зөвөлгөөнийг амжилттай зохион байгуулсан бөгөөд Булган суманд явагдсан 2 дугаар шатны зөвөлгөөнд оролцов. Хаврын бүтээлч ажлын хүрээнд нэг багш, ажилчин 1 цэцэг аян өрнүүлж, үрслүүлсэн цэцгээ суулгав. Прогресс сургуулийн 12 дугаар ангийн 3 бүлгийн 56 сурагч, 2 багшийн хамтаар сумын сургуулийн 12 дугаар ангийн сурагчид элсэлтийн ерөнхий шалгалтын сорил шалгалт өгч, спортын нөхөрсөг уралдаан тэмцээн зохион байгуулав.

Сумын Цэцэрлэгийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж урлагийн танхимаа тохижуулан 2 буйдан сандал шинээр хийлгэж гадна тохижилтондоо анхааран зүлэгжүүлэх, үрсэлгээ суулгах зэрэг ажлыг хийж нүйцэтгэлээ.

Хяналт шинжилгээ үнэлгээ хийх батлагдсан ажлын удирдамжийн дагуу хүнсний хадгалалт хамгаалалт, орчны эрүүл ахуйн байдалд МЭҮТ-ийн малын эрүүл мэнд хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Д.Ууганцэцэг, Мал үржлийн улсын байцаагч О.Жавзанханд нар хамтран хяналт хийж дүгнэлт өгч ажиллав.

Бүянт сум: 2017 оны 1 дүгээр ээлжийн Цэрэг татах ажиллагаа тус суманд зохион байгуулагдаж цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах хуудас авсан 22 иргэн Цэрэг татлагын комиссоор орж, 8 иргэн цэргийн жинхэнэ албанд тэнцэж, 4 иргэн хуулийн хүрээнд шийдвэр гаргууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд бие бялдарын чийрэгжилтийн түвшин тогтоох аян явагдаж эхлээд байна. Бүсийн сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн төгсөх ангийн сурагчдаас “Цахим сорилго” шалгалт авч анализ дүгнэлт хийн ажиллаж байна. Суурь болон бүрэн дунд боловсролын үнэмлэх гэрчилгээний захиалга өгч 33 төгсөгчийн судалгаа гаргав. Аймгийн мэргэжлийн хичээлийн олимпиадад 14 төрлөөр 13 багш 30 сурагч оролцож нийт дүнгээрээ 13 дугаар байр эзэлж багш Т.Солонго технологи дизайны чиглэлээр III байр, 10а ангийн сурагч Э.Ганчөдөр усан загвараар II байранд шалгарч мөнгөн медаль хүртсэн амжилт гаргалаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дунджыг 520-иос дээш оноо авсан үзүүлэлтийг тусгасан “Эцэг эх-багш-сурагч”-ийн гурвалсан гэрээ байгууллаа. Сурган хүмүүжүүлэх зөвлөлийн өргөтгөсөн хурал хийж 5-12 дугаар ангийн сурагчдыг анги бүрээр нь хичээлийн жилийн амжилт ололтыг сонсож танилцлаа. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн III шатны төсөл бичиж холбогдох газар болон аймгийн БСУГ-т хүргүүлээ. 1 дүгээр ангид суралцагчдын Цагаан толгойн эрдмийн баярыг тусгай хөтөлбөрөөр зохион байгууллаа. Аймгийн залуу багш нарын анхдугаар зөвлөгөөнд манай сургуулийн 13 багш амжилттай оролцлоо.

ᠨᠣᠶ᠋ᠠᠭᠤᠨ ᠴᠢ ᠪᠡᠢ ᠡ ᠠᠵᠤᠶ᠋ᠣᠶ᠋ᠡᠡᠢ жагсаалтыг гаргаж, ᠔ᠵᠵ᠔, ᠔ᠶᠡ ᠔ᠡᠢ ᠶᠡᠶᠡᠡᠢ ᠪᠣᠶ᠋ᠠᠢ ᠤ ᠢᠢᠢᠢᠢᠢ ᠰᠢᠳᠠᠪᠴᠢᠯᠰᠢᠨ ᠦᠵᠡᠰᠭᠢᠨ гаргав. ᠡᠳᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠣᠨ ᠨᠢ, ᠡᠭᠢᠢ ᠵᠡᠡᠡᠡᠡᠶ᠋ᠣᠢ ᠡᠡ ᠨᠶᠣᠶ᠋ᠡ ᠣᠠᠢ ᠠᠢ ᠶᠡᠡᠢ ᠨᠣᠶ᠋ᠠᠭᠤᠨ ᠠᠠᠨ, ᠠᠡᠡ ᠔᠔ᠵᠵᠠᠶ᠋ᠣᠳᠤ ᠵᠴᠠᠶ᠋ᠣᠳᠤ ᠵᠡᠡᠡᠡᠡᠶ᠋ᠣᠢ, ᠨᠢ, ᠡᠭᠢᠢ ᠡᠡᠡᠢ ᠣᠠᠡᠠᠠᠠᠳᠤ ᠨᠠᠢ ᠠᠡ ᠨᠢ ᠡᠡᠡᠡᠢ ᠠᠶᠡᠡᠡᠡᠠᠠ. ᠨᠣᠶ᠋ᠠᠭᠤᠨ ᠠᠢ ᠳᠠᠡᠣᠠᠢ ᠠ ᠴᠢ ᠳᠡᠣᠡᠶ᠋ᠠᠡᠡ ᠠᠡᠡ ᠠᠡᠠᠡᠶ᠋ᠣᠢ ᠡᠡ ᠠᠣᠶ᠋ᠠᠡᠡᠠᠢ ᠳᠡᠡᠶ᠋ᠣᠶ᠋ᠡᠵᠡᠡᠢ 10 ᠨᠣᠶ᠋ᠠᠭᠤᠨ-дыг ᠣᠠᠢ дуулан соёл, урлагийн үйлчилгээнд давхардсан тоогоор 1326 хүн үйлчлүүлж хамрагдсан байна.

Ховд, Мөст, Мянгад, Цаст-Алтай сургууль, Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх “Сайн хичээл” үйл ажиллагааны бүсийн зөвлөгөөнийг 04 дүгээр сарын 12-14-ны өдрүүдэд зохион байгуулж, тус үйл ажиллагаанд Ховд, Мөст, Мянгад, Цаст-Алтай сургуулийн багш нар оролцов.

Сумын эрүүл мэндийн төвөөр нийт 387 хүн үйлчлүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгт 55, гэрийн идэвхтэй эргэлтэд 55, диспансерийн үзлэгт 43, гэрийн дуудлага үйлчилгээгээр 48 хүнд эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүллээ. Томуугийн болон эх хүүхдийн мэдээг 7 хоног бүр өгч ажиллалаа.

“Тусгай дунд мэргэжилтний чадавхжуулах” уралдаан тэмцээнд амжилттай оролцож, багийн эмч Д. Тунгалаг 1 дүгээр байр, гар бөмбөгийн тэмцээнээс багаараа 3 дугаар байр эзэлж амжилттай оролцлоо. Цус, шээсний ерөнхий шинжилгээг 109 иргэнд, Иммунологи 10 хүнд тус тус шинжилгээнд хамрагдав. Тайлант сард 43 хүүхэд дархлаажуулалтын вакцинд 43 хүүхэд хамрагдахаас 36 хүүхэд хамрагдаад байна. Вируст гепатитын вакцинд байгууллагын бүх ажилчдыг хамруулж дархлаажуулалтын сарын мэдээг гаргав. 4 эхийг жирэмсний хяналтанд авч, шинжилгээнд нь хамруулан төрсний дараах үзлэг болон урьдчилан сэргийлэх үзлэгт 18 хамруулан ажиллалаа.

Эмч, дунд мэргэжилтнүүдийн эхний улирлын ажлын тайланг хамт олноороо хэлэлцэж, улирал бүр мэдлэгийн болон ур чадварын уралдаан шалгалтыг авч энэ нь ажилтнуудын ажлын үзүүлэлтийг дүгнэхэд шалгуур үзүүлэлтийн нэг болохоор гэрээнд тусгав.

Дөргөн сум: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн цай нийлүүлэх тендер шалгаруулалтыг 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион явуулж 2 аж ахуйн нэгж материал ирүүлснээс үнэлгээний хорооны дүгнэлтээр “Тээлийн буян” БГБХН шалгарч дүгнэлтийн дагуу үдийн цай нийлүүлэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг 3 сарын 31-нээс 4 сарын 11-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Судалгаанд 518 өрх хамрагдаж, судалгааны дүнг аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүллээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас орон нутаг дахь хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чадавх бэхжүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх сургалтыг зохион байгуулж, тус сургалтаар хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд харах үйлчилгээний журам, стандарт, түүний хэрэгжилт, залуучуудын чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, орон нутагт залуучуудын оролцоог идэвхижүүлж ажиллах арга зүйн талаар мэдээлэл өгсөн ач холбогдолтой сургалт болсон төдийгүй сургалтанд төрийн албан хаагч, залуучууд, эцэг эхийн төлөөлөл болох 70 гаруй иргэн, хүүхдийн төлөөллөөс 40 гаруй хүүхэд оролцож шинээр гарсан хуулиудын талаар мэдлэг мэдээлэлтэй боллоо.

Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс сумын ЗДТГ болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд 4 сарын 23-24-ны өдрүүдэд хяналт шалгалт хийж, санхүүгийн албанд хангалттай сайн гэсэн үнэлгээ өгч, цаашид ажлаа улам сайжруулж ажиллах 21 зөвлөмжийг өгсөн ба уг зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага 4 сарын 17-нд зохион байгуулж, цэргийн насны 1 дүгээр үүрэгтнүүдэд зарлан дуудах хуудас хүргүүлж, цэрэг татлагын комиссын үзлэгт 37 цэрэг хамрагдсанаас 17 цэрэг эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн болно.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын албаны ажлын хэсгийн бүрэлдэхүүн Агваш арал мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж тус нэгж 12.6 буюу зөрчилгүй үзүүлэлтээр шалгагдав. Аргалант багийн нутаг Хөх эргийн аараг хэмээх газар хууль бусаар алт олборлож байгаа ард иргэдэд хяналт тавьж ажиллах ажлын хэсэг байгуулагдаж тайлант сард 6 удаагийн хяналт хийснээс хууль бусаар алт олборлож байгаа 58 иргэнд мэдэгдэх хуудас хүргүүлж, хяналт шалгалтын үр дүнд хууль бусаар алт олборлож байгаа иргэд цөөрч байна.

Аргалант, Сээр багийн нутагт бөхөнгийн 2 удаагийн тандалт хийж, 8 бөхөнгийн сэг зэмыг цуглуулж, устгалын цэгт устгав.

Сум хөгжүүлэх сангийн өр авлага барагдуулах ажлын хэсэг байгуулагдан, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдэд зээл төлж барагдуулах мэдэгдэх хуудас хүргүүлэх ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 ангийн сурагчдын дунд стресс гэж юуг хэлэх, стресс тайлах арга барил, хүүхдийн эсрэг дарамт шахалт, facebook хэрэглээний ойлголт, сургуулийн орчинд хүүхдийн эсрэг аливаа эрсдэл эндэгдэл, сэтгэл санаа, үе тэнгийнхэний дарамт шахалт гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгууллаа.

“Хөдөлгөөн-бидний амьдралд” өглөөлгийг сумын ахмадуудын дунд зохион байгуулж, цэвэр агаарт өглөөний гүйлт, дасгал хөдөлгөөн хийхийн ач тусыг хэлж цаашид заншил болгож хэвшүүлэх ойлголтыг өгөв. Амхадууд тогтмол идэвхитэй хөдөлгөөнтэй байснаар цус харвалт, ясны сийрэгжилт, сэтгэл санааны хямрал, сэтгэл гутралын эрсдэлүүдээс өөрийгөө хамгаалж болох мэдээллийг өгөв.

“Гамшиг, ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” сургалтыг 11 дүгээр ангийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж тус сургалтаар гамшгийн тухай хууль /шинэчилсэн найруулага/, ойн хээрийн түймэр, түймрийн үед авах арга хэмжээ, түймрээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч ажиллав.

Соёлын төвийн хамт олон Завхан аймгийн Сонгино, Цэцэн-Уул, Сантмаргад, Ургамал сумдаар урлагийн аялан тоглолт хийж, туршлага судлан өөрийн орлогыг бүрдүүлж ажиллаа. Сар бүрийн 10-ны өдөр сумын нийт ахмадуудыг хамруулсан арга хэмжээ зохион байгуулдаг уламжлалын дагуу ахмадуудын дунд дууны болон бүжгийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

Цэцэрлэгийн гадна талбайг цэвэр үзэмжтэй, хүүхэд нэг бүр тоглож хөгжих бүрэн бололцоотой, осол аюулгүй эрүүл ахуйн шаардлага хангасан, туршилтын болон биеийн тамирын талбай тохижуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мэргэжлийн хичээлийн улсын олимпиадад багш, сурагчид амжилттай оролцсон төдийгүй газарзүйн багш Б.Амартүвшин 2 дугаар байр, Монгол хэлний багш З.Цэцэгмаа 6 дугаар байр, бага ангийн багш С.Буянхишиг 5 дугаар байр, биологийн багш Б.Баяржаргал 7 дугаар байр, англи хэлний багш Б.Эрдэнэцэцэг 6 дугаар байр эзэлж амжилттай оролцлоо. Сурагчдаас 7 дугаар ангийн сурагч Д.Бат-Очир сэтгэх чадварын олимпиадад 4 дүгээр байр, 12 дугаар ангийн сурагч Ц.Булган-Эрдэнэ биологийн хичээлээр 5 дугаар байр, 12 дугаар ангийн сурагч Р.Цагаанцоож Монгол бичгийн хичээлээр 5 дугаар байр, 12 дугаар ангийн сурагч П.Даваажаргал нийгмийн тухай мэдлэг хичээлээр 7 дугаар байр, 12 дугаар ангийн сурагч Л.Улаанхүү Монголын түүх хичээлээр 8 дугаар байр, 9 дүгээр ангийн сурагч Г.Намуунаа биологийн хичээлээр 9 дүгээр байр тус тус эзэллээ. ХоИС-ийн Сэтгэх чадварын олимпиадад 3

дугаар ангийн сурагч Э.Энхжин 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, 10 дугаар ангийн сурагч Э.Анужин 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль тус тус хүртэв. Монгол хэлний хичээлээр 12 дугаар ангийн сурагч Б.Машбат 5 дугаар байр эзэлсэн амжилтуудыг гаргалаа.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Бага олимп-2017” наадмын төрөл тус бүрт сурагчид амжилттай оролцлоо. Үүнд: даамны төрөлд 11 дүгээр ангийн сурагч П.Энхтөр 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, сагсан бөмбөгийн эрэгтэй сурагчдын баг тамирчид 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль хүртлээ.

Дэлхийн банк, БСШУСЯ хамтран хэрэгжүүлж буй Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд бага ангийн заах аргын нэгдэл нь “Эх хэл–хөгжлийн түлхүүр” төслийн төслийг яаманд хүргүүлэв. Уг төслийг хэрэгжүүлснээр бага ангийн хүүхэд нэг бүр үндэснийхээ эх хэл, өв соёл, ёс заншлаа эрхэмлэдэг үзэлтэй болгох, тэдний үгийн баялгийг нэмэгдүүлэн хэл яриаг хөгжүүлэх, чадварт сургах

Соёл, хүмүүжлийн ажлын хүрээнд спортын болон танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, тэмцээний үр дүнд хүүхдүүд авьяас чадвараа нээн илрүүлж, хөгжүүлэх, багаараа хамтран ажиллах чадварт суралцах, хүүхдүүд өөр хоорондоо эерэгээр нөлөөлөх, спортоор харилцааны хүмүүжил олж авах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх чадварт суралцсан болно.

Манхан сүм: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран ахлах ангийн сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” мэдээлэл хийлээ. Мөн сурагчдын дунд “Бие хүн гэж хэн бэ”, “Харилцаа” гэсэн сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж сурагчдын саналыг сонслоо.

“Тайван амгалан орчин бүрдүүлэхэд-иргэн миний оролцоо” сэдэвт аяныг өрнүүлэн иргэдийн дунд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, тус сургалтаар “Гамшгийн тухай хууль”, “Тамхины хяналтын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” сэдвүүдээр сонсгол мэдээлэл хийв. Аяны хүрээнд “Өөрчлөлтийг өөрөөсөө”, Архи тамхигүй хамт олон болох уриатайгаар ажиллаж байна.

2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2017 оны 04 сарын 21-нд цэрэг татлагын комисстой хамтран зохион байгууллаа. Нийт 44 цэрэг зарлан дуудах хуудас хүлээн авснаас 6 хүн цэргийн албанд тэнцэв.

Сумын газар тариаланчдын зөвлөгөөнийг ДЗОУБ-тай хамтран зохион байгуулж, тус зөвлөгөөнд 60 гаруй тариалан эрхлэгчид, сумын удирдлагууд, албан хаагчид оролцож 2016 оны ажлаа дүгнэж 2017 оны тариалалт болон тулгамдсан асуудлаа хэлэлцлээ.

Азийн хөгжлийн банкны санхүүжилт, тусламжаар ирсэн 10 хүлэмжийг ашиглалтанд оруулах зорилгоор иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 17 иргэн оролцсноос 10 иргэн хүлэмж эзэмших хүсэлт гаргаж тухайн иргэдийг бүлэг болгон ахлагчаар нь Н.Бээжинхүү томилогдон хүлэмжийн тариалалтыг эхлүүлэхээр болов. Өмч хамгаалах комиссын болон санхүүгийн албаны 2017 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулав.

“Тайван амгалан орчин бүрдүүлэхэд-иргэн миний оролцоо” сэдэвт 9 сарын аян зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тамхины хяналтын тухай хуулийн сургалтыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран 2017 оны 04 сарын 15-ны өдөр төрийн албан хаагчид болон ард иргэд, ахлах ангийн сурагчдад зохион байгууллаа.

Аж ахуйн нэгж, албан байгууллагуудын удирдлагуудад Тамхины хяналтын тухай хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт нийт 17 хүн хамрагдаж тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийн талаар санал бодлоо солилцов.

Ховд аймагт зохиогдсон мэргэжлийн хичээлийн олимпиадын II даваанд амжилттай оролцож Түүхийн хичээлийн улсын олимпиадаас багш Ц.Мөнхбат I байр эзэлж алтан медаль, Нийгмийн хичээлээр багш Р.Бум-Эрдэнэ III байр эзэлж хүрэл медаль, 12а ангийн сурагч Б.Мягмаржав Монгол бичгийн хичээлээр III байр эзэлж хүрэл медаль, 10а ангийн сурагч Б.Майцэцэг мэдээлэл зүйн хичээлээр I байр эзэлж алтан медаль мөн ХоИС болон нэрэмжит олимпиадуудаас нийт 16 медаль тус тус хүртсэн амжилттай оролцлоо.

Биеийн тамир спортын газар үүсч хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд аймгийн ЕБС-иудын дунд зохиогдсон “Ховд-2017” хүүхдийн спортын бага наадамд Ч.Гантулга, Т.Одгэрэл, Ш.Мөнхцоож нарын дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож хөдөөгийн сумдын сургуулиудаас нийлбэр дүнгээр тэргүүн байрт шалгарлаа.

Аймагт зохиогдсон 2,3,4 дэх жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд 11 багш мөн Улаанбаатар хотод зохиогдсон 5 дахь жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд Нийгмийн ажилтан Д.Ганзориг, Физикийн багш Ц.Хашбаатар, Англи хэлний багш Г.Хаш-Эрдэнэ нар хамрагдлаа. Мөн Жаргалант суманд зохиогдсон “Чадварлаг залуу багш” сэдэвт залуу багш нарын анхдугаар чуулга уулзалтанд 6 багш спортын таван төрөлд амжилттай оролцон багш Э.Ариунжаргал 100 буудалт даамны төрөлд III байр, багш М.Саруул теннисний төрөлд IV байр тус тус эзэлж багш Ц.Мөнхбат “Чадварлаг залуу багш” илтгэл хэлэлцүүлэв. “Бүсийн сайн хичээл” зөвлөгөөнд бага, дунд ангийн төлөөлө 16 багш хичээл болон СДҮАЦ-г зохион байгуулж багш Н.Олонбаяр АЧСҮАЦ, багш Ц.Мөнхбатын “Шинжлэх ухааны ололт, нээлтүүд” сэдэвт хичээл, бага ангийн багш Ж.Баасанхүүгийн АЧСҮАЦ зэрэг хичээл шалгарч амжилттай оролцов. Төгсөх ангийн сурагчдын судалгааг гаргаж БСУГ-ын статистик хариуцсан улсын байцаагчид хүргүүллээ.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд орох нийт 53 хүүхэд бүртгэж, бүртгэлийн хуудсыг хянуулж баталгаажуулав. ОНОС дэд хөтөлбөрийн хүрээнд I-V ангиудын дунд “Тоглох өдөр”, VI-IX ангиудын дунд “Би”-ийн өдөр, X-XII ангиудын дунд “Талархалын өдөр” зэрэг өдөрлөгүүдийг багш, эцэг эх, олон нийтийн оролцоотой хамтран зохион явуулав. Сурагчдыг гэмт хэрэг, болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор “Оройн эргүүл багш” сарын аяныг өрнүүлэн багш нар өдрийн 17⁰⁰ цагаас оройн 22⁰⁰ цаг хүртэл тусгай хуваарийн дагуу эргүүлд гарч, дотуур байрны сурагчдын амьдрал ахуйтай танилцах, сурагчдын хичээлд туслах, тэдний санал бүсэлтийг сонсох, орчин нөхцлийг сайжруулах зорилгоор “Хамтдаа...” аяныг өрнүүлэн ажиллаж байна.

Байгууллагын гадна тохижилтод анхааран зүлэгжүүлэх талбайг засах, мод тарих нүх ухах, сад татах, хог ачих зэрэг аж ахуйн ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн нийтийн номын сангийн зөвлөн туслах багийн бүрэлдэхүүн сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, фондын номыг эмхлэн цэгцлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Сайн хичээл бүсийн зөвлөгөөний үеэр хөгжүүлэх сургалтаар /Математикийн энгийн төсөөлөл, Хөдөлгөөн эрүүл мэнд/ 2 чиглэлийн үйл ажиллагааг багаараа бэлтгэн амжилттай оролцлоо. Тус зөвлөгөөнд “Шүлгээр хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх нь” сэдэвт илтгэл бичиж хэлэлцүүлэв. Аймгийн “Чадварлаг залуу багш”-ийн зөвлөгөөнд багш Б.Оюунжаргал илтгэл тавьж спортын төрлөөр амжилттай оролцов. Мөн багш, ажиллагсдын дэлгэрэнгүй судалгаа гарган аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон БСУГ-т хүргүүлэв.

Сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан 4,5,6 дугаар саруудад хийгдэх ажлын төлөвлөгөөний багш нарт сургуулийн удирдлагын зүгээс үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв нь иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тухай бүр нь үзүүлж, 404 хүнд үзлэг шинжилгээ хийв. Урьдчилан сэргийлэх үзлэгт 217 хүн хамруулсан ба эмнэлэгт 38 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 33 хүүхэд хамруулсан төдийгүй 3 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 14 дуудлаганд үйлчлэв. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хүүхдийн цэцэрлэгийн бага бүлгийн 2 ангийн 70 хүүхдэд гарын ариун цэвэр, шүд угаах сургалт зохион байгуулж, 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна.

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалтай газар нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран Өөшийн хөдөө, Бор үзүүр чиглэлийн бөхөнг тоолж, тус орчмын газарт 210 гаруй бөхөнг байгааг тогтоов. Сумын Засаг даргын Захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж хүлэмж байгуулах талбай, хашаа үзэх, хүлэмжийг хэрхэн ашиглах хэлэлцүүлэг зохион байгуулж, тус арга хэмжээнд 17 иргэн оролцож санал бодлоо солилцон 10 иргэн хүлэмж ашиглах саналаа өгч зөвшөөрлийг олгов.

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалтай газар нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран Баянгол гол багийн нутаг “Нуурын хаяа” хэмээх газар галууны хяналт шалгалт хийж, нүүдэллэн ирж буй шувуу, ан амьтдыг үргээж, хороохгүй байх яриа таниулгыг гутгийн иргэдэд хийв. Төгрөг гол багийн Засаг даргатай хамтран тухайн багийн нутаг дэвсгэрт амьдарч буй 20 нохойг устган ариутгал, халдваргүйжүүлэлт хийж улстгалын цэгт булж устгав.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн 3 мэргэжилтэн, бүрэн дунд сургуулийн Бөхөн клубын 6 хүүхэдтэй хамтран сумын хэмжээнд ирвэсийн бүс нутагт 5 ширхэг камер байрлууллаа.

Сумын газар тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнд 60 гаруй иргэд, газар тариаланчид хамрагдсан ба газар тариаланчдыг дэмжигч Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хамтран ажиллав. Мал эмнэлэгийн үржлийн стандартын үзлэг, аттестатчлалд 6 нэгж хамрагдахаас 4 нэгж хамрагдаж 1 нэгж тэнцэж, 3 нэгж нь дахин шалгуулахаар чиглэл авлаа. МЭҮН-үүдэд хуваарилагдсан вакцинийг татан авч хуваарилалт хийсэн ба сар бүрийн мэдээ тайланг хүлээн авч холбогдох дээд шатны байгууллагад уламжилж байна. Аймгийн ХХААГ-т долоо хоног бүрийн 3 дахь өдөр төл бойжилт, хорогдлын мэдээг цаг хугацаанд нь хүргүүлж байна.

Алтай сүм: Аймгийн улсын бүртгэл тасгийн дарга С. Хоролсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг “Нэг иргэн-нэг бүртгэл” сэдэвт иргэдийн өдөр зохион байгуулж, иргэний бүртгэлээр 32 иргэн, эд хөрөнгийн бүртгэлээр 63 иргэн, гадаад паспортын сунгалт 16 иргэн нийт 146 иргэнд үйлчилгээг тус тус үзүүлэв.

4 сарын 17-21-ний өдрүүдэд 4 багийн иргэдийн Нийтийн хурал болж, Сумын Засаг даргын 100 хоногт хийсэн ажлын тайлан мэдээлэл, Багийн Засаг даргын хийсэн ажлын тайлан, 2017 онд хийх ажлын төлөвлөгөө, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, нийт 410 иргэд хамрагдав. Аймгийн ЗДТГ-ын цэргийн штабын дарга, хурандаа Т.Эрдэнэчулуунаар ахлуулсан ажлын хэсэг, аймгийн Эрүүл мэндийн газрын эмч Д.Цээпилээр ахлуулсан эмч нарын багтай хамтран ээлжит цэрэг татлагын ажилд комиссоор орж 18 цэргийн зарлан хүргэснээс 7 цэрэг тэнцлээ. Сумын газар тариалангийн зөвөлгөөн болж 37 хүн оролцож бүлэг нөхөрлөлийн 26 га талбайд хамгаалалт тогтоов.

Эрүүл мэндийн төв нь сумын нийт 3130 хүн ам ба мал аж ахуйн 3 баг, сумын төвийн 1 багт эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж, үзлэг шинжилгээ, оношилгоо хийн ажиллаж байна. 4 дүгээр сард амбулаторийн үзлэгт 320 /давхардсан тоогоор/ хүн хамрагдсаны 33 өвчтөнг хэвтүүлэн эмчилсэн ба үүнээс том хүн 27, хүүхэд 6 өвчтөнг эмчлэв. Нөхөн үржихүйн насны 13 эмэгтэйд үйлчилгээ үзүүлсэн төдийгүй 3 жирэмсэн эхийг эхний 3 сартайд нь, 4 сартай 1, 7

сартай 1 эхийг хяналтанд авч ажиллав. Мөн төрсний дараах 42 хоногтой эх нярайд эргэлт хийж зөвлөгөө өгч ажилласан байна. Хөх, умайн хүзүүний хавдрын шинжилгээнд 4 дүгээр сард зорилтот насны хамрагдвал зохих 15 эмэгтэйгээс, 13 эмэгтэй хамрагдаж хамралт 86,6 хувьтай байна. Эмнэлгийн нэг гол үзүүлэлт болох урьдчилан сэргийлэх тариалгад хамрагдвал зохих 34 хүүхдээс 31 хүүхдийг хамруулж, хамралт 91 хувьтай байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас вакцины татан авалтыг 1 удаа хийсэн ба дархлаажуулалтын санамж зөвлөмжийг шинэчлэн гаргаж, ажил үйлчилгээндээ мөрдөн ажиллаж байна. Цус болон шээсний ерөнхий шинжилгээ 47 удаа, цусны бүлэг тодорхойлолтын шинжилгээг 5 хүнд хийсэн ба тестийн оношлуураар ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээ 5 хүнд, В, С вирусын маркерийн шинжилгээг 169, эмнэлгийн ажилчдаас 10 хүн, жирэмсэн 5 хүнийг хамруулснаас В вирус 15, С вирустай 25 хүн оношлогдоод байна. Мөн хеликобактерийн шинжилгээнд 1 хүн хамрагдсанаас 3 хүнд хеликобактер илэрсэн. Сахарын шинжилгээ 6 хүн, цэрний шинжилгээний сорьц 4 хүнээс авч, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторт илгээв. 0-5 насны хүүхдийн эндэгдэл гараагүй, 1,4 дүгээр сард давхардсан тоогоор 75 хүнд ЭХО оношилгоо хийснээс онош тодруулах шаардлагатайн улмаас дээд шатны эмнэлэгт 7 өвчтөнг шилжүүлээд байна.

4 дүгээр сарын 19-ны өдөр баруун бүсийн эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийн ур чадварын уралдаан зохион байгуулж, багийн эмч С.Алтантуяа, сувилагч Б.Саруулзаяа нар тэргүүн байр эзэлж, Ч.Сувд-эрдэнэ, Х.Түмэнжаргал онооны эрэмбээр шалгарч, гар бөмбөгийн тэмцээнд Б.Саруулзаяа ахлагчтай эмнэлгийн баг 1 дүгээр байр эзэлж, дунд мэргэжилтэн болон, аймгийн Эрүүл мэндийн газарт болсон Дэлхийн эрүүл мэндийн эмч нарын өдрийн тэмцээнд тус тус амжилттай оролцов.

Мэргэжлийн хичээлийн олимпиадад Биологи-газарзүйн багш Ардын боловсролын Тэргүүний ажилтан О.Бямбасүрэн амжилттай оролцож алтан медаль хүртэж Улсын олимпиадад оролцох эрх авлаа. Сайн хичээл бүсийн 2 дугаар зөвлөгөөн Булган суманд болж нийт 17 багш, удирдлагууд оролцов. 2017 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд болсон “Хүүхдийн спортын бага наадам”-д амжилттай оролцож 46 ангийн сурагч Э.Бат-Эрдэнэ даамны тэмцээнд амжилттай оролцож 3 дугаар байр эзэлж, хүрэл медаль, 10а ангийн сурагч Б.Цогзолмаа 100 метрийн гүйлтийн тэмцээнд амжилттай оролцож 2 дугаар байр мөнгөн медаль, 10б ангийн сурагч А.Ариунзаяа, 800 метрийн гүйлтийн тэмцээнд амжилттай оролцож 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль, мөн 100 метрийн гүйлтийн тэмцээнд амжилттай оролцож 3 дугаар байр эзэлж хүрэл медаль тус тус хүртлээ.

Хүүхдийн цэцэрлэгийн багш Н.Булганцэцэг “Сайн үйл ажиллагаа-сайн туршлага” бүсийн уулзалтанд математикийн чиглэлээр, хөдөлгөөн-эрүүл мэндийн чиглэлээр багш Т.Цэцэгмаа, “Сайн туршлага” илтгэлд багш Т.Эрдэнэцэцэг нар амжилттай оролцож зохих амжилтыг үзүүлэв.

Мянгад сүм: Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал тайлант сард 1 удаа хуралдаж багуудын Засаг дарга нарын ажлын хэрэгцээний компьютер худалдан авах хөрөнгө шийдвэрлэх тухай, Мал эмнэлгийн нэгжүүдийн 2017 оны санхүүжилтийн хуваарь батлах тухай, сумын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай, Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлуудыг хэлэлцэн баталлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь аппаратын өргөтгөсөн зөвлөгөөнийг зохион байгуулж ажилтан, албан хаагчид байгууллагын 2017 оны 01 дүгээр улиралын ажлын тайланг хэлэлцэж, орон нутагт хийгдэх цаг үеийн болон, 2 дугаар улиралд хийгдэх ажлын төлөвлөгөөг баталлаа.

Тус суманд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сан, Орон нутгийн өмчийн газрын хамтарсан ажлын хэсэг 04 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд ажиллаж, Монгол улсын Төсвийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд түүнд нийцүүлэн гаргасан бодлогын баримт бичгүүд, эрх зүйн акт, заавар, журмуудын хэрэгжилт, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, Төсвийн орлого болон ОНХС-ийн бодлогын хэрэгжилт, Санхүүгийн тайлагнал санхүүгийн эрх, Төрийн сангийн үйл ажиллагаа, Төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн НББ-ийн тухай хуулийн хэрэгжилт, Орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа.

Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд ажиллаж, шинээр батлагдсан, шинэчлэн найруулагдаж, нэмэлт өөрчлөлт орсон Гэр бүлийн хүчирхийллийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар холбогдох байгууллага албан тушаалтанд зөвөлгөө өгч, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгсний дээр үүрэг хүлээгчдийн чадавхи бэхжүүлэх сургалтыг зохион байгуулж уг сургалтанд төрийн албан хаагч, иргэд, хүүхэд, сумын Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүд нийт 130 гаруй хүн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/133, дугаар захирамжийн дагуу 2017 оны 1 дүгээр ээлжийн Цэрэг татах ажиллагаа тус суманд 2017 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр зохион байгуулагдаж цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах хуудас авсан 51 иргэн Цэрэг татлагын комиссоор орж, 7 иргэн цэргийн жинхэнэ албанд тэнцэж, бусад иргэд нь хуулийн хүрээнд шийдвэр гаргууллаа.

Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр: 2017 оны 04 дүгээр сард Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 11, гэрлэлт 4, нас баралт 2, үрчлэлт 1, шилжин явсан 8, шилжин ирсэн 7, хашаа байшингийн гэрчилгээ шинээр авах 1, иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ. Тус суманд 2017 оны 04 дүгээр сарын 10-нд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс “Нэг иргэн нэг бүртгэл иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил” уриан дор хууль эрх зүйн чиглэлээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 80 гаруй иргэн оролцож ЭХЭУБ-ийн чиглэлээр 8, гадаад паспортын захиалга 15, иргэн зөвөлгөө, үйлчилгээ авлаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, газрын харилцааны чиглэлээр: Монгол хадран загасны үржлийн үеийг тохиолдуулан хадран загасны шилжилт хөдөлгөөний үеийн хууль бус агнуурыг таслан зогсоох, шилжилт хөдөлгөөнийг саадгүй явуулах зорилгоор тус сумын Байгаль хамгаалагч 10 хоногийн хугацаанд Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтран Ховд голын цутгалуудаар 6 чиглэлд 10 удаагийн хяналт шалгалт зохион байгуулан, загас агнахыг завдсан 18 иргэнтэй уулзан, 5 удаагийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажиллагааг зохион байгууллаа.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн 5 иргэний өргөдөл хүлээн авч 2 өргөдлийг Засаг даргын захирамжаар бүрэн шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна. Мөн энэ сард хамтран өмчлөлөө салгуулсан 66 иргэний судалгаа, нөхөн сэргээх газрын судалгаануудыг гаргаж аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хүргүүлжээ.

Газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудын төлбөрийн ногдуулалтыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар болон аймгийн Татварын албанд хүргүүлсэн ба энэ онд газрын төлбөрт 3500,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2017 оны 01 дүгээр улирлын байдлаар 2200,0 мянган төгрөгийн орлогыг аймгийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна.

Мянгад суманд үржүүлж буй “Мянгад” адуунд явуулсан үржил селекцийн ажлын үр дүнд хянан магадлагаа хийх ажлын хэсэг болох ХХААХҮЯ-ны МАА-н бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч доктор Д.Батмөнх, МАА-н эрдэм шинжилгээний орлогч захирал Б.Бейсен, аймгийн ХХААГ-ын МАА-н хэлтсийн дарга Г. Бат-Өлзий, АОШЛ-ийн их эмч Б.Мөнхбаатар, ХХААГ-ын МАА-н албаны мэргэжилтэн С.Шүрхүү нар тус сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдтэй хамтран цөм сүрэг, тохиромжтой хэвшил, удам бүлгийн адууны тоо толгой, адууны тарга хүч гүйцээгүй байгаа буюу хаврын адууны жин, биеийн үндсэн хэмжээ, үржлийн цөм сүргийн мал болон түүнийг маллагч малчдын 10 хүртэл хувийг хамруулсан судалгааны ажлыг хийж эхлээд байна.

Санхүү, бүртгэлийн чиглэлээр: 2017 оны 04 дүгээр сард татвар төлөгчийн бүртгэлийн болон тооцооллын үлдэгдлийн мэдээллийг татвар төлөгчтэй тулган баталгаажуулалт хийн урьд оны татварын өртэй байсан татвар төлөгч А.Авдалын 80.0 мянган төгрөг, Мянгад чаргат хоршооны 20.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн хяналт шалгалтын өр 200.0 мянган төгрөг, Б.Черханы 13,0 мянган төгрөг барагдуулсан ба А.Баатархааныг газрын төлбөр төлөгчөөр шинээр бүртгэж 16.0 мянган төгрөг төлүүлсэн байна.

Засгийн газрын төлбөр тооцооны төрийн сангийн фрийбаланс программын тусгай шилжүүлгээр санхүүждэг болон орон нутгийн төсөвт байгууллагуудын сар бүрийн санхүүжилтийг төвлөрүүлэн өдөр тутмын гүйлгээг анхан шатны баримттай тулган гүйлгээг шивж, Төсөвт байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг тухай бүр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн орон нутгийн байгууллага 0 мянган төгрөгийн 0 гүйлгээ, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 26.313.400 мянган төгрөгийн 27 гүйлгээ нийт 26.313.400 мянган төгрөгийн 27 гүйлгээг хийж гүйцэтгээд байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд тэжээгчээ алдсаны тэтгэмж нийт 19 иргэнд 1216,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр 104 иргэнд 14560,0 мянган төгрөг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж нийт 23 иргэнд 1472,0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж 49 иргэнд 1960,0 мянган төгрөгийн тус тус тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Шимтгэлийн орлого 22050,1 мянган төгрөг, Иргэний Сайн дурын даатгалд 29 иргэнээс 2350.1 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалд 31 иргэнээс 1235.0 мянган төгрөг, Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлд 2 иргэнээс 156.2 мянган төгрөг нийт 25791,4 мянган төгрөгийн орлого орууллаа. Мөн 7 иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлж тэтгэврийн тогтоолтыг хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 100823.1 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэвэр 291 хүнд 78950.7 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 35 хүнд 6026.7 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 76 хүнд 13160.7 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд 302.3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тус тус олголоо.

Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр: Эрүүл мэндийн төв нь энэ сард нийт 449 амбулаторийн үзлэг хийж 28 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 25 алсын дуудлаганд явж, 0-3 сартай 3 жирэмсэн эхийг эрт хяналтанд авч, хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 13 эмэгтэйчүүдийг 100 хувь шинжилгээнд хамруулж ажиллалаа. Товлолын дархлаажуулалтыг 2-4 сартай нийт 7 хүүхдэд Тавт вакцин, 9 сартай 6 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцин, 1-2 настай 11 хүүхдэд А гепатитын эсрэг вакцин, 2 настай 8 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцины 2 дахь тунг тус тус тарьж дархлаажуулалтыг товлолын дагуу хийж

үйлчилэв. Тайлант санрд нийт 22 албан бичиг ирсэний 8 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн хяналтанд авч нийт 5 бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр: Өсөх нахиа Хүүхдийн цэцэрлэг нь 2017 оны 4 дүгээр сард хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байгаа төдийгүй Цагаанбулан багийн төвд Гэр цэцэрлэгийг 10 хоногийн хугацаатай ажиллуулж нийт 20 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгов. Багш Н.Нямцэцэг хөгжмийн багшийн мэргэжлийн олимпиадад 1 дүгээр байр эзэлж Өргөмжлөл алтан медиалиар шагнуулсан ба багш Б.Болорсүвд хөдөлгөөн эрүүл мэндийн олимпиадад амжилттай оролцлоо. Чадварлаг багш нарын зөвлөгөөнд багш А.Одонжаргал өөрийн бичсэн илтгэлээр амжилттай оролцож, цэцэрлэгүүдийн сайн үйл ажиллагааны 4 дүгээр бүсийн зөвлөгөөнд багш Ц.Энхтуяа хөдөлгөөн эрүүл мэндийн чиглэлээр, багш Г.Цэндхүү математикийн энгийн төсөөлөл чиглэлээр тус тус амжилттай оролцлоо.

Соёл урлагийн үйлчилгээний чиглэлээр: Соёлын төв нь 2017 оны 04 дүгээр сарын 06-нд Эрүүл мэндийн төв Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хамтран төрийн албан хаагч, иргэдийн дунд сэтгэл судлалын нэг өдрийн сургалт зохион байгууллаа. Номын сангаар нийт 128 иргэн үйлчлүүлж, нийт 291 ном авч, бүжгийн дугуйланд нийт 58 хүүхэд суралцсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР